

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

1

*Хуралдааны товч тэмдэглэл:*

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:*

- 
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны 10 дугаар сарын 25-ны  
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 25 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: С.Ганбаатар, Ц.Сандаг-Очир.

Байнгын хорооны дарга П.Анужин “Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэхийг хойшлуулав. /09:27/

**Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын аудитын удирдлагын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Х.Баярмаа, Санхүү-нийцлийн аудитын газрын менежер Ц.Хосжаргал, П.Чанцалдулам, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Сандуйжав, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын Б.Тэлмүүн, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч Ж.Алтантуяа, мэргэжилтэн А.Мөнхжаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн С.Гэлэгжунай, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Хонгорзул, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүү, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Дамбийням, Төрийн захиргаа удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Батсүх, Нийгмийн

даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батмагнай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Отгонбаатар, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ш.Батцэнгэл нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Б.Баярсайхан, М.Оюунчимэг, Ц.Туваан, Ж.Чинбүрэн, Б.Жаргалмаа, Д.Сарангэрэл нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Дамбийням нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 55 минут үргэлжилж, 17 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 88.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 20 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

П.АНУЖИН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр,  
Лхагва гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим, 09 цаг 25 минут

### **НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**П.Анужин:** Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52,9 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя.

Баярсайхан гишүүн, Батлут гишүүн, Бейсен гишүүн, Жаргалмаа гишүүн, Одонтуяа гишүүн, Туваан гишүүн, Чинбүрэн гишүүн, Чинзориг нарын гишүүд хуралдаанд хүрэлцэн ирсэн байна. Бадарчийн Жаргалмаа гишүүн хүрэлцэн ирсэн байна. Түрүүн уншсан, тийм ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Байнгын хорооны тогтоолын төсөл. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Түүний дараагаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд.

Эдгээр асуудлыг өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор өөр саналтай гишүүд байна уу? Санал байхгүй байна.

1 дүгээр асуудал. Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгуулах ийм асуудал орж ирсэн. Энэ асуудлыг бид нар Эрүүгийн хууль болоод мөн Хууль зүйн яаман дээр боловсрогдож байгаа Гэр бүлийн хуультай нийцүүлэн энэ ажлын хэсгийг бас байгуулах шаардлагатай гэж үзсэн тул энэ асуудлыг өнөөдөр хойшлуулж байна.

2 дугаар асуудалдаа оръё.

**Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дахь хэлэлцүүлгийг хийнэ.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг зааланд урьж байна. Байна уу.

Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн сайд ирж байна уу? Сангийн сайд Болдын Жавхлан ирж байгаа юм байна. Содномын Чинзориг Эрүүл мэндийн сайд, Хүрэлбаатарын Булгантуяа Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд. Булгантуяа сайд хаана байна? Булгантуяа сайдыг дуудаарай. Санжаагийн Мөнгөнчимэг Сангийн дэд сайд,

Үндэсний аудитын газар. Наранчимэг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, ирсэн байна уу? Ирсэн

байна. Самбууням Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Мөнхцацрал Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын аудитын удирдлагын менежер, Баярмаа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Хосжаргал Санхүү-нийцлийн аудитын газрын менежер, Чанцалдулам Санхүү-нийцлийн аудитын газрын менежер, Энхбаатар Үндэсний аудитын газрын ахлах аудитор, Сандуйжав Үндэсний аудитын газрын ахлах аудитор, Сандуйжав ирээгүй байна уу? Энэ ажлын хэсгийн гишүүдийг дуудаарай. Даваадорж Үндэсний Аудитын газрын ахлах аудитор, Даваадорж. Наранчимэг дарга танайхан бүрэлдэхүүн маш дутуу ирсэн байна. Хүмүүсээ гүйцээгээд хуралдаа оруулна уу.

Сангийн яамнаас. Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Алтантуяа Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч, Мөнхжаргал Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Гэлэгжунай Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн,

Мөнгөнхүлэг Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Хангал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Сансармаа Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн.

Эрүүл мэндийн яамнаас ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Төгсдэлгэр. ЭМЯ, ЭМЯ Төгсдэлгэр. Төгсдэлгэрийн нэрийг өгөөгүй байгаа юм байна. Энд өгсөн. Энд дарсан юм байна. Лувсан Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн Засгийн газрын дарга, Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хаана байна. Мөнхцэцэг Эрүүл мэндийн яамны Санхүү даатгалын хэлтсийн дарга, Хонгорзул Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Бямбасүрэн Эрүүл мэндийн даатгалын сангийн ерөнхий газрын дарга, Энхтуяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ийм бүрэлдэхүүнтэйгээр ирсэн байна

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Булгантуяа сайд ирсэн үү? Орж ирж байна. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам. Ганхүү Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Алимаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Баярмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Тунгалагтамир Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжүүлэлтийг зохицуулах газрын дарга, Батсүх Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ганцэцэг НДЕГ-ын бодлогын хэрэгжилт судалгааны газрын дарга, Нямсүрэн, Өлзийхутаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Өлзийхутаг,

Батмагнай Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг та бүхэнд танилцуулна. Сангийн сайд Б.Жавхланг микрофонд урьж байна. Сангийн сайд Жавхлан хэлэлцүүлэгт байгаа юм байна. Төсвийн төслийг Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг танилцуулна.

**С.Чинзориг:** Байнгын хорооны дарга, гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 24 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд Монгол Улсын эдийн засаг сайжирч, улмаар урт хугацааны хөгжлийн эхний 10 жилийн зорилт болох шинэ сэргэлтийн бодлогоо хэрэгжүүлэх боломж бүрдээд байна. Тиймээс шинэ сэргэлтийн бодлогын гол зорилтын нэг болох хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно.

Ирэх 2024 онд нийгмийн бодлогын чиг хэлээр хэрэгжүүлж зарим онцлог арга хэмжээг дурдвал,

1. Шинэ сэргэлтийн бодлогын тулгуур бүрэлдэхүүн болох хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтод тусгасан

хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, хөгжил дагасан бүтээн байгуулалтыг хийх, эдийн засгийг тэлэхэд чиглэсэн төсвийн арга хэмжээ,

2. Инфляц, амьжиргааны түвшин, цалин хөлсний дундаж өсөлттэй уялдуулан төрийн албан хаагчдын цалинг нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр болон нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхиээлтэй хүүхдэд олгох тэтгэмж, нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхиээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эхэд олгох тэтгэмжийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 10 хувиар нэмэгдүүлэх,

3. Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд малчдын төлөх НДШ-ийн 50 хувийг, мөн хөгжлийн бэрхиээлтэй хүүхдээ асарч байгаа иргэний шимтгэлийг 100 хувь тус тус төсвөөс хариуцах, нийт даатгуулагчдын тэтгэвэр тогтоолоход баримтлах дараалсан 7 жилийг 5 жил болгон бууруулах, тэтгэврийн хуримтлалын нөөц санг мөнгөжүүлэх,

4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх,

5. Хөдөөгийн сумд ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчдад сар бүр үндсэн цалингийн 40 хувиар. Харин аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт ажиллаж байгаа дээрх ангиллын төрийн албан хаагчдад сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тус тус нэмэгдэл олгох зэрэг арга хэмжээний зардлыг төсвийн төсөлд тусгаад байна.

Байнгын хорооны дарга, гишүүд ээ, Ирэх 2024 онд төсөв санхүүгийн бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25,3 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн зарлага 27,4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2,1 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2,8 хувь болж төсвийн тусгай шаардлага хангагдаж байгаа болно.

Иймд ирэх оны төсвийн төсөлд нийгмийн бодлогын чиглэлээр тусгагдсан арга хэмжээтэй танилцаж, улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**П.Анужин:** Чинзориг сайдад баярлалаа.

2024 оны төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Наранчимэг танилцуулна. Наранчимэгийг микрофонд урьж байна, 3 номерын микрофоныг өгье.

**Ц.Наранчимэг:** Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн дүгнэлтэд аудит хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан,

эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн 7 зорилтын хүрээнд хянаж үнэлэхэд аудитын зорилго чиглэсэн. Төрийн аудитын байгууллага Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн байна гэж дүгнэж байна. Үүнд:

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289,8 тэрбум, ДНБ-ий 34,2 хувь, нийт зарлага 27 их наяд 360,5 тэрбум, ДНБ-ий 37 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70,8 тэрбум төгрөгийн алдагдалтай, ДНБ-ий -2,8 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулахад улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан дараах зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөвлөсөн байна.

Шинэ сэргэлтийн бодлогод тусгасан хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, экспортыг дэмжих, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эрчимжүүлэх, иргэдийн орлогыг хамгаалж, цалин тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, уул уурхайн орлогоос орон нутгийн хөгжлийн санд нэмэлт орлого хуваарилах, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулах, тогтвортой, хариуцлагатай уул уурхайг дэмжиж, байгалийн баялгийн үр

өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх гэсэн байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг дараах байдлаар төсвийн төсөлд тусгажээ.

Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд: төвлөрүүлэх орлого 38,5 тэрбум төгрөг, зарлагыг 3 их наяд 942,2 тэрбум төгрөг.

Эрүүл мэндийн сайд: төвлөрүүлэх орлогыг 5,5 тэрбум төгрөг, зарлагыг 1 их наяд 651,2 тэрбум төгрөг.

Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэх орлогыг 3 их наяд 691,4 тэрбум төгрөг. Зарлагыг 4 их наяд 690,1 тэрбум төгрөг.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төвлөрүүлэх орлого 2 их наяд 2,2 тэрбум төгрөг, зардлыг 1 их наяд 970,6 мянган төгрөгөөр тус тус төсвийн төсөлд тусгасан байна.

Төрийн албан хаагчдын цалинг нэмсэнтэй холбоотойгоор нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 1 их наяд 290,6 тэрбум төгрөгөөр өмнөх оноос нэмэгдүүлэн төсөвлөжээ. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2023 оны тодотгосон төсвөөс 2 их наяд 294,6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 12 их наяд 254,1 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөн нь иргэдийн орлогыг хамгаалах арга хэмжээний хүрээнд тэтгэвэр тэтгэмж болон төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэх бодлого баримталсантай холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны хэрэгжүүлэх хөтөлбөр нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго зорилттой нийцэж буй хэдий ч

Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээнээс ЭМЯ дараах 4 хөтөлбөр, арга хэмжээг тусгаагүй байна. Үүнд:

Эм нийлүүлэлт, худалдан авалтыг оновчтой зохион байгуулж, эмийн чанарыг сайжруулах, эмчилгээний хамгийн сүүлийн үеийн зааварчилгаа туршилага хуваалцах платформд бүрэн холбогдох, бүх шатын эмнэлэг, эмийн сангуудад ашиглагдах нэгдсэн өгөгдлийн систем үүсгэх, телемедицин нэвтэрсэн эрүүл мэндийн байгууллагыг нэмэгдүүлэх гэсэн ийм зорилтууд байна.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны төсвийн багцад 299 тэрбум төгрөгийн 133 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд 185,5 тэрбум төгрөгийн 91 арга, хэмжээ тусгагдаж 113,5 тэрбум төгрөгийн 42 төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна. Үр дүнд чиглэсэн төсвийн төлөвлөлтийн аргыг улсын болон орон нутаг, мөн салбарын төсөвлөлтөд хэрэгжүүлснээс бий болох үр өгөөж, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор хэмжих үзүүлэлтийг тодорхой болгож, хүрэх үр дүнг богино, дунд хугацаагаар тодорхойлж, үйл ажиллагааг хэмжсэнээр төсвийн зардлын ашиглалт, үр өгөөж нэмэгдэх, төсөвлөсөн хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжтой байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд дараах нийтлэг дүгнэлтийг өгсөн болно.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүйгээс төсвийн зорилго



хангагдах хэсгийг үнэлэх боломжгүй байна.

Гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн алдагдлыг тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна.

Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд магадлал хийгдэж байгаа 21, 1 маягаар болон жишиг магадлалтай 153 төсөл, арга хэмжээг тус тус тусгасан байна. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах, захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, улсын комисс, барилга байгууламжийг хүлээн авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан, субъектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд дараах асуудлыг толилуулж байна.

Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа улсын хөгжлийн төлөвлөгөөний зорилт, зорилго, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусгуулахад анхаарах,

Монгол Улсын Засгийн газар дараа жилийн төсвийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихдаа төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна гэж үзэж байна.

Төсвийн төслийг боловсруулах тухайн үе дэх хүчин төгөлдөр

мөрдөгдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх, улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх,

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч хэрэгжилтэд нь хяналт тавих,

Хөгжлийн бодлогод нийцүүлэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж, чадавхыг сайжруулахыг Засгийн газарт зөвлөж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**П.Анужсин:** Баярлалаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд урьдчилан хүргүүлсэн байгаа.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүнээр тасалж байна. 2 гишүүний нэр ороогүй байна. Кноп дарсан боловч Бадарчийн Жаргалмаа гишүүн, Сарангэрэл гишүүн нарын нэрсийг асуулт асуух гишүүдийн нэрсийн дараалалд оруулж өгнө үү. Ажлын хэсэг.

Даваажанцангийн Сарангэрэл гишүүнээр асуулт асуух гишүүдийн

нэрсийг тасалж байна. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

**С.Одонтуяа:** Нийгмийн даатгалтай холбоотой бас Булгантуяа сайдаас хэд хэдэн зүйл асуух гэсэн юм. Сая Чинзориг сайдын илтгэлд нэг тийм үг гарлаа. Нийгмийн даатгалын энэ хуримтлалын санг бий болгохдоо гэсэн нэг асуудал яригдах юм. Тэгэхээр ер нь улс яг хэдэн төгрөгийн өртэй байгаа юм бэ? Миний бодлоор нэг 21 их наяд гэж би багцаагаар бодоод байгаа. Тэр зөв үү. Энэ ер нь ямар үе шаттайгаар энэ хуримтлалын санг бий болгох гэж байгаа юм бэ гэдгийг асуух гэсэн юм.

Одоо хүмүүс чинь тэтгэвэрт гарахад бол ерөөсөө тэтгэврийн мөнгө нь нэрийн данс дээрээ байхгүй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр тайлбар өгөөч.

2 дугаарт, энэ хүүхэд хамгааллын төсөв дээр маш олон гишүүд хэлээд байсан. Анхан шатад нь жоохон мөнгө тавиач ээ, тэр хамтарсан баг, цагдаа сэргийлэх. Дээгүүрээ ингээд л баахан хурал, зөвлөгөөн элдэв долоон яам, тамга ингээд л, энэ дээрээ л данхайгаад байдаг. Доод шатанд төсөв байдаггүй гээд. Тэгэхээр энэ доод шатанд ер нь төсвөө яаж хуваарилсан юм бол оо гэсэн.

3 дугаарт, энэ ахмад настнууд нөгөө жилдээ 1 удаа амралт, сувиллын газар нэг 50 хувиа төлөөд амардаг нэг ийм хууль байдаг. Тэгэхээр ер нь энэ хэдэн хувьтай байдаг юм бэ? Нийт тэтгэвэр авагчдын багцаа нь хэдэн хувь нь жилдээ энэ эрхээ эдэлдэг юм бол оо? Би бас энэ дээр нэг хууль санаачлах гээд тэгээд энэ тоо хэрэгтэй байгаа.

Түр байрууд дээр ер нь төсөв харагдахгүй байна. Түр байрууд чинь улам л дүүрэн шүү дээ, цаашидаа. Одоо бүр хүн нь багтахгүй байгаа.

Гэр бүл салалт маш их байгаа гээд байгаа. Тэгэхээр энэ гэр бүлийг

дэмжсэн бодлого дээр ер нь ямар нэгэн төсөв, хөтөлбөр тавьсан байгаа юу гэдгийг асууя.

Чинзориг сайдаас нэг товчхон юм асуучихъя. Энэ Зүрх судасны төв эхлэх гэж байгаа юм байна. Энэ бол маш чухал. Энийгээ яаж ийгээд бид нар бариад дуусгах хэрэгтэй. Нас баралтын 1 дүгээр шалтгаан шүү дээ.

2-т, энэ аймаг, дүүргүүд дээр энэ хүүхдийн нэг судас тариа гэхэд нэг судас тодотгогч гээд байдаг юм. Тэр нь нэг 8 сая төгрөгийн үнэтэй юм шиг байна. Үүнийг энэ бүх аймаг, дүүрэгт ядаж 1, 1-ийг аваад өгч болох уу. Үүнийг та нэг судалж үзсэн болов уу Эрүүл мэндийн яамнаас асуух гэсэн юм. Яагаад гэхээр хүүхдийн өвчлөл ихэснэ. Хүүхдийн эмнэлгээр орохоор л ерөөсөө тариа хийлгэхэд л нэг орилсон хүүхдүүд байх юм. Тэгэхээр тэр судас тодотгогчийг нь судалсан юм. Нэг нь бүх суурьтайгаа нийлээд нэг 8 сая юм байна. Үүнийг нэг аймаг, дүүргүүдэд ядаж аваад өгчих боломж байгаа болов уу гэсэн ийм л товчхон асуулт.

**П.Анужин:** Одонтуяа гишүүний асуултад Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Булгантуяа хариулна.

Булгантуяа сайдыг хариулахаас өмнө нэг зүйлийг анхааруулж хэлэхэд улсын төсвийн энэ гол тулгуур болсон нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай асуудлыг хэлэлцэж байхад энэ эрхлэх сайд бол заавал байлцмаар байгаа юм. Гэтэл өнөөдөр 10 цагаас Хүүхэд хамгааллын сонсгол зарлачихсан байдаг. Энэ мөн байлцах ёстой чухал асуудал. Тэгээд өмнө нь улсын төсөв хэлэлцэж байхад энэ цаг нараа зөв зохицуулах тухай шаардлагыг бас хэлсэн боловч үүнийг хүлээж аваагүй давхиулсан. Гэсэн хэдий ч Байнгын хорооны даргын хувьд нийгмийн даатгалын сангийн төсөв хэлэлцэж байхад харьяа сайд байхгүй байж болохгүй. Өчигдөр зарим мэргэжлийн Байнгын хороодод эрхэлсэн

сайдууд байхгүйгээс сайдын багц гэсэн нэг бүлэг багц оруулж ирээд багцаа гишүүдэд тайлагнахгүй ийм асуудлууд гарч ирсэн. Ингэх ёсгүй. Улсын төсвийг бид нар ингэж замбараагүй цалгардуулж, хэлэлцүүлж болохгүй учраас салбар хариуцсан яамдын сайдуудыг заавал байхыг үүрэг болгож байна.

Булгантуяа сайд асуултад хариулья.

**Х.Булгантуяа:** Хүүхэд хамгааллын тухай зардлын хувьд бол 8 тэрбумаас 14 тэрбум төгрөг болгож нэмэгдүүлж байгаа гол зардал нь ерөөсөө кэйс дээр ажиллах, кэйс буюу анхан шатан дээр ажиллаж байгаа манай нийгмийн ажилтнууд, хамтарсан багийн санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилготой байж байгаа. Үүн дотор ахиад түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ гээд улсын хэмжээнд 30 гаруй ийм байр байдаг. Эдгээр байрууд руу чиглэсэн дээрээс нь нэмээд хүмүүс яах вэ, кэйс гэж нэрлэлээ гэж юу яагаад байх шиг байна. Хамгийн гол нь бид нар ямар тохиолдол гэж нэрлэлтэй нь биш. Хэргийн бүртгэл гэж нэрлэхэд их хэцүү. Мэргэжлийн салбарынхан нь өөрсдөө кэйс менежмент гээд тухайн хүүхэд дээр ямар нэгэн эрх нь зөрчигдсөн нөхцөл байдал үүссэн байх юм бол очиж үнэлгээ хийдэг, тухайн хүүхэд дээр холбоотой бүртгэлийг үүсгэдэг. Энэ хугацаанд нь сэтгэл зүйн зөвлөгөө, түр хамгаалах байранд байриуулсан, хуульч, өмгөөлөгч авч өгсөн гэх мэтчилэн. Шаардлагатай бол эцэг эхээс нь тусгаарлаж, асрамжийн газарт байриуулах гэх мэтчилэн эхнээс нь эцэс хүртэл нь ямар алхам хийсэн бэ гэдэг талаарх бүртгэл мэдээлэл байдаг. Үүн дээр эхнээс нь эцэс хүртэл ажиллахад төсөв санхүүжилт хүрэлцэхгүй байгаа гэдэг энэ асуудал бол анх энэ хуулийг батлагдахад ярьж байсан. Тэгээд үүнтэй холбоотойгоор 14 тэрбум төгрөг нэмэгдэж байгаа нь түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээтэй

бас холбоотой бас нэмэгдэж орж ирж байгаа гэсэн үг.

Гэхдээ үүнтэй нэмэгдээд бас орон нутаг маань бас үүн дээр нэлээдгүй дэмжлэг үзүүлэх бол шаардлагатай байна. 3, 4 жилийн өмнөхтэй харьцуулах юм бол мэдээж түр хамгаалах байранд байгаа ажиллаж байгаа ажилчдын зардлаас авхуулаад хувьсах зардлууд ч гэсэн халаалт, дулаан хэрэглэгдэхүүний зардлууд ч гэсэн хоол, хүнс бас нэмэгдэж орж ирсэн.

Гэр бүлийг дэмжихтэй холбоотойгоор бид нар бас ирэх жил ялангуяа энэ 14 тэрбумаа л чадан ядан бүгдэд нь л хүргэх гэж бид нар зорьж байна. Хүүхэд хамгааллын тухай хууль, дээрээс нь нэмээд Гэр бүлийн тухай хуулийг ХЗДХЯ-наас өргөн барих гэж байгааатай холбоотойгоор бид нар мэдээлэл, сурталчилгааны ажлуудыг шинэ хуультай холбоотойгоор бас нэлээдгүй хийх хийж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Одонтуяа дарга бас сайн мэдэж байгаа байх. Ер нь өмнөх хийсэн хэд хэдэн төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудын хийсэн судалгаагаар гэр бүл гэр бүлээрээ нэг цаг өнгөрөөх ийм барилга байгууламжаас авхуулаад ялангуяа хотын захын хороодод бол ийм хөгжлийн төвүүд их дутагдмал байдаг. Захын хороодод бол хорооны байрнаас өөр иргэд рүү чиглэсэн ерөөсөө барилга байгууламжууд байхгүй байна. Энэ бол илүү их засаг захиргааны байр байгаад байна гэдэг ийм шүүмжлэл байдаг. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Гэр бүл хөгжлийн жишиг төвийн зургийг гаргасан. Бид нар ирэх жил 1-2 байрыг шинээр эхлүүлэхээр улсын төсөв дээр тавиад байна.

Сангийн алдагдлын хувьд гэх юм бол одоогоор НДШ тэтгэврийн шимтгэл төлөгчдийн хувьд бол нэрийн данс дээр бичээд явдаг. Үүн дээр нийтдээ 27 их наядын бичилттэй явж байна гэсэн үг, 27 их наядын, тийм, 27 их наядын

бичилттэй явж байгаа. 2022 оны байдлаар. Бид нар шинэ Нийгмийн даатгалын багц хууль 2023 онд сая батлагдаад 24 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхлэх гэж байгаатай холбоотойгоор тэтгэврийн шимтгэлийн 2 хувийг мөнгөжүүлэх буюу 389 тэрбум төгрөг байхаар санд юунд суусан байж байгаа, төсөвт суучихсан, 24 онд 389 тэрбумыг мөнгөжүүлнэ ээ гэсэн байж байгаа.

2022 оны байдлаар 49,9 мянган ахмад рашаан, сувилалд бол амарсан, амарч байгаа. Үүнд 8,2 тэрбум төгрөгийг зарцуулсан байгаа. Тийм 49,9 мянган ахмад рашаан сувилалд амарч байгаа. 8,2 тэрбум төгрөгийг зарцуулсан байгаа 2022 онд. Амралт рашааны л. ЭМД-аас нөгөө рашаантай холбоотой юмнууд нь шаардлагатай бол ингээд тодруулж болно.

**П.Анужин:** Салдангийн Одонтуяа гишүүний асуултад Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг хариулт өгнө.

**С.Чинзориг:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Ер нь 24 оны улсын төсөв дээр эрүүл мэндийн салбарт шаардлагатай байгаа хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд хэд хэдэн асуудлууд тусгаж байгаа. Олон жил яригдаж байгаа энэ эс эд эрхтэн шилжүүлэн суулгах төвийг 2024 оны төсөвт 142 тэрбум төгрөгийн өртөгтэй тусгаж, 24 онд санхүүжих дүн 42 тэрбум төгрөгөөр энэ төвийг шинээр барьж эхлүүлэх ажлыг тусгаж байгаа.

2 дугаарт, хавдар болоод зүрх судасны төвүүдийг бас барих ажлыг эхлүүлэх, ялангуяа инженерийн дэд бүтцийг нь бас хийхэд 2024 оны улсын төсөв дээр тусгаж байгаа. Зүрх судасны төвийг бол цаашидаа бид нар энэ инженерийн хийцтэй дэд бүтцийг нь 24 оны төсөв дээр тусгаж хийе. Хөрөнгө оруулалтын асуудлыг нь энэ Японы хөрөнгө оруулалтаар бас барья гэсэн ийм асуудал яригдаж байгаа.

Тэр хүүхдийн судас тодосгогчтой холбоотой асуудал шинэ технологи юм байна лээ. Үүнийг бид нар бас судалж байгаа. Тэгээд сайдын багц дээр 2023 онд тоног төхөөрөмжийн зардал 1 төгрөг ч тавигдаагүй байсан бол 24 онд бас тодорхой хэмжээгээр сайдын багц дээр тоног төхөөрөмжийн зардал бол тусгагдаж байгаа. Энэ хүрээнд шийдэх бас боломжтой.

2 дугаарт, манайх гүйцэтгэлийн санхүүжилтийн аргаар санхүүжилт эмнэлгүүд авч байгаа учраас эмнэлгүүд ч гэсэн өөрсдийнхөө бас гүйцэтгэлээрээ санхүүжилтээр авах ийм боломжтой. Үүнийг бид нар ер нь ирэх жил нэвтрүүлнэ гэсэн ийм бодолтой бол байгаа. Манайхны надад өгч байгаа мэдээллээр шинэ технологи байгаа юм гэсэн ийм асуудал ярьж байгаа. Тэгээд ер нь нэлээн тийм нэвтрүүлэх чиглэлийн асуудлууд зохион байгуулна гэж бодож байгаа.

**П.Анужин:** Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууна.

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Би Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нэг 2 асуулт асууя. Энэ Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөрт Алсын хараа 2050 үзэл баримтлалтай холбоотой хүний хөгжлийн бодлого боловсруулна гэсэн энэ зорилт ерөөсөө хэрэгжихгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ зорилт энэ жил сүүлийн жил бодлого нь боловсруулагдах уу гэдэг нэг асуулт байна.

2 дугаарт, сая Монгол Улсын Ерөнхий сайд санаачлаад энэ ахмад настнуудын оролцоо, ахмадын оролцоо гэдэг үндэсний чуулганыг зохион байгуулсан. Энэ дээр энэ ахмадын хөдөлмөр эрхлэлт, тэдний бас хөгжих энэ чөлөөт цаг аятай тухтай өнгөрөөх энэ асуудлыг бас бодлогын хүрээнд дэмжинэ гэсэн. Энэ жил энэ төсөв байгаа юу. Энэ дээр юу хийгдэх вэ гэж асууя.

Эрүүл мэндийн сайдаас хэд хэд асуулт байна. Өмнө нь Энхболд сайдын үед бас асууж байсан. Энэ сумын эмнэлгүүдэд шүдний эмчийн орон тоо баталдаггүй юмаа гэхэд шүдний кабинет заавал байх ёстой байна. Яагаад гэвэл манай Завхан аймаг 5 бүсэд хуваагддаг, маш том газар нутагтай, тархан суурьшдаг. Тэгээд ядаж бүсийн 5 эмнэлэг дээрээ шүдний эмчтэй байлаа гэхэд сум дээр очоод тэр кабинетдаа хүүхдээ очоод үзчихдэг ийм боломж нөхцөлийг нь бүрдүүлж өгөөч гэж бас энэ 3 жил бид нар ярьж байгаа юм. Тэгээд энэ асуудал туссан уу?

2 дугаарт, энэ Энхболд сайд ноднин жилийн төсөв дээр сумын эмнэлгийг модон жорлонгоос нь салгана. Улсын хэмжээнд 10 сумын эмнэлэг модон жорлонгоосоо салж, 5 Завхан аймагт хийгдэнэ гэсэн. Энэ ажил яг ямар түвшинд явж байгаа вэ. Эрүүл мэндийн яамны анхнаасаа асууя.

Эрт элрүүлгийн асуудлыг улс даяар чухалчилж байгаа боловч Завхан аймаг 75 мянган хүнтэй, дундаа ганцхан ходоодны дурангийн аппараттай. Тэгээд энэ жилийн төсөв дээр энэ ядаж манай Тосонцэнгэлийн эмнэлэгт дурангийн аппарат, энэ юу сум дундын эмнэлгүүдэд ходоодны дурангийн аппарат өгөх боломжтой юу? Аймгийн төв дээр ганц дурангийн эмнэлэгтээ бид нар эрт элрүүлгийг бол хийх ерөөсөө боломжгүй байгаа. Үүнийг би бас удаа дараа ярьж байгаа.

Түргэн тусламжийн машиныг бол 7 сум ямар ч машингүй болсон. Тэгэхээр энэ сумын эмнэлгүүдэд түргэн тусламжийн машин шийдэх энэ жил боломжтой байна уу. Өвлийн хүйтэнд бид нар хол зам хэцүү ийм багуудтай байдаг. Тэгээд хүндээ хүрч очих асуудал бол үнэхээр хүндрэлтэй байдаг. Тэгээд сүүлийн хэдэн жил Завхан аймаг бас нэлээн зудтай ийм хэцүү хавар, өвөлтэй ингэж нүүр тулж байгаа гэдгийг бас хэлье.

Эцэст нь бас нэг зүйл асууя, Чинзориг сайд аа. Энэ нийгмийн эрүүл мэндийг дэмжих тал дээр энэ жил танай яам яг ямар төсөв тавьсан бэ? Юу хийх вэ. Яамнаас үүнийг бодлогоор та нар өөрсдөө очиж хүмүүсийг соён гэгээрүүлж ажлаа хийх юм уу, эсвэл үүнийг ямар нэгэн төрийн бус байгууллагууд хийх ёстой юм уу, ОУБ хийж байгаа юу? Энэ ард иргэдийг соён гэгээрүүлэх, амьдралын чанараа дээшлүүлэх, зөв шим тэжээлтэй хоол, зөв хөдөлгөөнтэй амьдрахад энэ ард иргэдийг соён гэгээрүүлэх ажилд төсөв ажил юу хийгдэх гэж байгаа юм бэ гэдэг энэ асуултуудад тодорхой хариулт авъя. Баярлалаа.

**П.Анужин:** Баярсайхан гишүүний асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа хариулна.

**Х.Булгантуяа:** Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын тухай хуулийн Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого гэж орсон байдаг. Хүн амын хөгжлийн нэгдсэн бодлого нь ганцхан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэхээсээ илүүтэйгээр бас боловсрол, дээрээс нь нэмээд эрүүл мэнд, эдийн засаг гэх мэтчилэн бусад яамдын асуудалтай шууд уялдаж учраас Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хүрээнд эрхлэх асуудлын хүрээнд орсон байж байгаа. Мөн бүтцийнхээ хувьд Эдийн засаг, хөгжлийн сайдын бүтцэд Хөгжлийн нэгдсэн бодлогын газар дотор Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс гэж байдаг. Тухайн хэлтэсээс энэ бодлого гарч ирнэ ээ гэж бид ойлгож байгаа. Тэгээд манай яамны зүгээс бол хөдөлмөр нийгмийн хамгаалалтай холбоотой бүхий л асуудлыг хангаж, ажлын хэсэгт хамтран ажиллахад бол бэлэн байж байгаа.

Ахмадын чуулганы хувьд сая 10 сарын 01-нд Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл доор ахмадын чуулганыг 21 аймаг, 9 дүүргийн төлөөлөлтэйгөөр зохион байгууллаа. Ахмадуудын маань зүгээс хүсэж байгаа гол асуудал бол ахмадын хөдөлмөр эрхлэлт, мөн ахмадын санг байгуулахаар ахмадын настныг дэмжих энэ хуульд нь оруулсан ч гэсэндээ Төсвийн тухай хуультай зөрчилдөөд байгаа асуудлыг ахмадын чуулган дээр ярьсан байж байгаа. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүн, ТББХ-ны дарга Нямаа Энхболд дарга, Улсын Их Хурлын гишүүн Баделхан гишүүд оролцсон ахмад настныг дэмжих лобби бүлгийг УИХ дээр байгуулж, хуулийн энэ зөрчлийн асуудлыг 1 дүгээрт арилгах энэ ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна.

Мөн ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусдаа хууль, эрх зүйн орчинтой байх уу, үгүй юү гэдэг асуудал дээр манай дээр мөн Нямаа Энхболд дарга гээд мөн ахмадын байгууллагууд оролцсон ажлын хэсгийг бид нар бас байгуулаад явж байгаа. Үүнтэй холбоотойгоор бид нар ирэх жил Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энэ хууль, эрх зүйн орчныг сайжруулаад энэ хөтөлбөрийг давхар тусгахаар Ерөнхий сайдаас бас үүрэг чиглэл өгсөн байгаа.

**П.Анужин:** Асуултад Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг хариулт өгье. Чинзориг сайдын микрофон нь ажиллахгүй байна. Ажиллалаа.

**С.Чинзориг:** Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 66 орчим хувь нь шүд цооролттой байна гэсэн ийм статистик мэдээ гарсан. Энэтэй холбоотойгоор ер нь хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой асуудал, шүд цооролтыг эмчлэхтэй холбоотой асуудал дээр Засгийн газар нэлээн анхаарал

хандуулж байгаа. Засгийн газарт асуудал оруулаад 24 оноос хүүхдийн шүд цоорлыг эмчлэх “шүд” гэсэн ийм төсөл, хөтөлбөр бас хэрэгжүүлэхээр Засгийн газрын тогтоол бол гаргасан. Энэтэй холбоотойгоор шаардагдах хөрөнгийг нь улсын төсвөөс нэг хэсгийг нь, нэг хэсгийг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр ингээд төсөвт бол тусгаад явж байгаа.

Бид нар 330 сумтай боловч харамсалтай нь гучхан сум нь л кабинеттай, шүдний эмчтэй. Шүдний цооролт эмчлэх тоног төхөөрөмжтэй гэсэн ийм судалгаа бол байгаа. Тэгээд 330 сум үндсэндээ ерөөсөө эзэн байхгүй, тоног төхөөрөмж ч байхгүй, эмч ч байхгүй. Тэгэхээр бид энэ “шүд” төслийн хүрээнд сумдад ялангуяа энэ хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулах замаар хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалуулах, шүдний цооролтыг эмчлэх ийм арга хэмжээ авна. Нэг хэсэг газруудад нь эмчтэй болгох, тоног төхөөрөмжөөр хангах ийм бас арга хэмжээ авна гэж бол төлөвлөж байна.

2 дахь асуудал, тэр эрт илрүүлэхтэй холбоотой асуудал дээр сумдыг бид ходоодны дурантай болох боломж бол байхгүй. Аймгийн төвүүдийн нэгдсэн эмнэлгүүдийг харин тэр ходоодны дурангийнх нь оптик дуранг нь нөөц ээлжийн оптик дурантай болгох арга хэмжээ авч байгаа юм. Ингээд нийтдээ нэг бүх аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд ээлжийн оптик дурантай болгох арга хэмжээ яаман дээр тендер зарлаад одоо худалдан авалт нь хийж байгаа. Ингэвэл бас жаахан эргэлт нь сайжрах болов уу гэж бодож байна.

Тосонцэнгэл сум бас харьцангуй сум дундын нэгдсэн эмнэлэг гэсэн ийм статустай явдаг учраас ирэх жилийн тоног төхөөрөмжийн зардлаас бас Тосонцэнгэл дээр ходоодны дурантай болгох арга хэмжээг судлаад шийдэх ийм боломж бол гарах байх гэж л бодож

байна. Бусад сумдад бол энэ ходоодны дурангаар хангах ийм боломж бол байхгүй.

Түргэний унаатай холбоотой асуудал 2023 оны улсын төсөв дээр 1 ч төгрөг тоног төхөөрөмжийн зардал тавигдаагүй учраас түргэний унаа шийдэх боломжгүй байгаа. Гэхдээ бид нар Японы Жайка төслийн хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлгүүдийг туулах чадвартай унаагаар хангасан. Зарим бас төрийн өмчийн мэдэлд байсан зарим бас унааг орон нутгийн өмчийн мэдэлд шилжүүлэх замаар бас зарим нэг сумын унааг бол шийдэх арга хэмжээ бол авсан.

2024 он онд бид нар нийт сумдынхаа нэг 30 хувийг нь Япон улсад үйлдвэрлэгдсэн тоёота Ланд Круизер 77 гэсэн ийм маркийн автомашинаар хангахаар төлөвлөж байна. 30 хувийг. Энэ үндсэндээ улсын төсвөөс биш Дэлхийн банкны санхүүжилтээр ийм бас арга хэмжээ авна гэж төлөвлөж байгаа. Ингээд ирэх жилийн 5 сарын дотор бид нар нийт сумдынхаа 30 хувийг нь ийм туулах чадвартай машинаар хангахаар төлөвлөж ажиллаж байна.

Нийгмийн эрүүл мэндтэй холбоотой асуудал үнэхээр их чухал. Бид нар сүүлийн жилүүдэд бол энэ эмчлэн эмнэлгийн тусламж үйлчилгээ дээрээ анхаарал хандуулъя. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэлээн орхигдуулж ирсэн байна гэж үзэж байгаа. Хуулийн төсөл өргөн барьчихсан. Гишүүд маань харин энэ чуулганаар төсөв баталсны дараагаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг батлаад өгвөл их сайн байна. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хууль батлагдвал нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг байхаар хууль явж байгаа. Энэ чиглэлийн зардалд нь мөнгө, төсөв нь бол улсын төсөв дээр туссан.

Соён гэгээрүүлэх иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх асуудал үнэхээр их чухал. Засгийн газарт иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар авах арга хэмжээг тогтоолоор оруулж батлуулсан. Салбар хоорондын 5 яам хамтарсан төлөвлөгөө гаргаж ажиллана. Ийм чиглэлийн ажлыг нэлээн бас эрчимжүүлэх хэрэгтэй гэж бодож байгаа гэдгийг бас та бүхэнд бас хэлэхийг хүсэж байна.

**П.Анужин:** Чинзориг сайд асуултад гүйцээж хариулъя. Чинзориг сайд нэмэлт 1 минут өгье.

**С.Чинзориг:** Ер нь бид нар энэ иргэний эрүүл мэндийн боловсролын асуудлыг онцгой анхаармаар юм байна лээ. Үндсэн хуульдаа иргэн эрүүл мэндээ хамгаалах нь иргэний журамт үүрэг мөн гэсэн Үндсэн хуулийн заалттай. Үүнийг хэн ч ярьдаггүй, төр ч ярьдаггүй, иргэн ч ярьдаггүй, эмнэлгийн байгууллага ч ярьдаггүй. Нөгөө талаасаа энэ эрдэмтэн судлаачид олон улсын байгууллагуудын туршилага эд нар чинь харахаар иргэний эрүүл зөв амьдралын хэв маяг чинь иргэн хүний өөрийнх нь эрүүл байх урт наслахын чинь бараг л 55 орчим хувь нь үүнээс шалтгаалдаг гэсэн ийм судалгаанууд гараад ирнэ шүү дээ. Бусад орнуудын туршилага ч ийм байна. Тийм учраас энэ иргэний эрүүл мэндийн боловсролын асуудалд нэлээн онцгой анхаарал хандуулах ёстой. Харин Сангийн яам бидний энэ бодлогыг дэмжиж, иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр зохих хэмжээний хөрөнгө санхүүгийн эх үүсвэр төсөвт тус тусаж өгсөн. Манай салбар дээр дутагдалтай хамгийн хүндрэлтэй байгаа асуудалтай таны яриад байгаа нолийн асуудал бол байна. Энэ талаар хийгдэж байгаа юм байхгүй. Шулуухан хэлэхэд ирэх оны төсөв дээр ч гэсэн энэ талаар төлөвлөсөн юм бол байхгүй. Бусад төслүүдийн хүрээнд харин Хүүхдийн сан, хүн амын сантай бид нар бол ... /минут дуусав/

**П.Анужин:** Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууя.

**Б.Баярсайхан:** Энэ хүний хөгжлийн бодлого бол маш чухал асуудал байгаад байгаа юм. Тэгээд хүн ам зүйн бодлого гэдэг чинь нэг өөр, хүний хөгжлийн бодлого гэдэг чинь бас өөр байгаад байгаа юм. Тэгээд би өөрөө бас зарчмын зөрүүтэй санал гаргаад Эдийн засгийн хөгжлийн яамны нэгдсэн чиг үүрэг дотор хүний хөгжлийн нэгдсэн бодлогоор хангана гэсэн нэг ийм зорилтод нь ийм зорилт тусгуулж байсан. Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам бусад яамдтайгаа хамтраад Монгол Улсад хамгийн их энэ тулгамдаад байгаа хүний хөгжилд анхаарч, хүний хөгжлийн бодлогоо яаралтай боловсруулах шаардлагатай байгаа гэдгийг хэлье.

Энэ дээр Эдийн засгийн хөгжлийн яам бас нэмээд хариулбал хариулаарай. Чинзориг сайдын тэр юуны асуудал дээр энэ Чинзориг юу, Энхболд сайдын үед ажиллаж байсан газрын дарга нар байна уу, энд. Тэр 10 сумын эмнэлгийн модон жорлонг өнгөрсөн оны төсөв дээр тавилаа бүр яг тавьсан гэж хэлж байсан. Энэ санхүүжилт хаашаа явсан бэ? Үүнийг асууя.

**П.Анужин:** ЭМЯ Төрийн нарийн бичгийн дарга хариулъя микрофонд. Юу ч гэсэн хариул микрофонд хариулт өгье. ЭМЯ, Эдийн засаг хөгжлийн яамнаас. ЭМЯ 3 номерын микрофонд очоод хариулт өгье. 3 номерын микрофонд хариулт өгье.

Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн Засгийн газрын дарга Лувсан. НҮБ-ын хүн амын сангаар энэ нолийн асуудлыг шийдэхээр яригдаж байсан боловч шийдвэрлэгдээгүй, төсвийн асуудал батлагдаагүй тэгээд зогссон байсан.

**П.Анужин:** Эдийн засгийн хөгжлийн яамнаас хүн ирээгүй байна.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууя.

**М.Оюунчимэг:** Бид нар үнэхээр маш чухал асуудлууд хэлэлцэж байгаа. Аливаа зүйлд маш бодитой хандах хэрэгтэй байгаа. Яагаад гэвэл эдийн засгийн өсөлтийг бид 7 хувь, Жи Ди Пи ДНБ-д 74 их наяд гээд бид том тоо ярьж байна. Бас эерэг үзүүлэлтүүд гарч байна. Тэгэхээр үүнийг яг хүн рүүгээ чиглүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэндийн чиглэлийн тулгамдаж байгаа асуудлуудаа шийдэх гээд энэ бол өнөөдөр маш том зорилт байгаа юм. Тэгээд энэ хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцыг ингээд аваад үзэхэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2024 оны төсвийг 23 оныхтой харьцуулахад 9 орчим тэрбум төгрөгөөр буюу 9,3 хувиар буурчихсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөдөлмөрийн ажлын байр дэмжих төсөл, хөтөлбөрүүд юм уу энэ зорилго нь. Тэгсэн хэр нь 2024 онд нийгмийн халамж, хөтөлбөрийн зардлын төсөв нь 8,2 хувиар нэмэгдчихсэн орж ирж байна л даа. Нөгөө халамжаас хөдөлмөрт гэдгийнхээ эсрэгээр нь болчихсон ийм зорилт оруулаад ирж байна. Тэгээд аудитын дүгнэлт, Улсын Их Хурлын хяналт шалгалтын энэ хэлтсээс энэ тэр дүгнэлтийг харахад өнгөрсөн хугацааны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн үр дүн маш хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай байгаа, үйлчилгээний чанар үр өгөөж нь буурчихсан. Хөтөлбөрт 4 их наяд төгрөг орчим зарцуулсан хэр нь хамрах хүрээ хэт хязгаарлагдмал цөөн арга хэмжээнд хэт өндөр төсөв зарцуулсан байна гэсэн дүгнэлтийг бас энд гаргачихсан байна л даа. Тэгээд энэ их сургалт, семинарт асар их мөнгө төгрөг зарцуулсан хэр нь яг энэ сургалтад хамрагдсан иргэдийн 20 хүрэхгүй хувь нь түр ажлын байранд хамрагдсан гэсэн судалгааг энд гаргасан байна л даа. Тэгээд энэ цаашидаа бид яах юм бэ. Нээрээ л үнэнийг хэлэхэд бид мөнгөний бодлого дээрээ ч, төсөв дээрээ ч аль болохоор иргэдээ ажлын байраар дэмжих, ажлын байр олноор бий болгож



тэгж байж иргэд орлоготой байна. Тэгж байж энэ нөгөө бид нарын яриад байгаа хүүхэд хамгаалал энэ тэр чинь эцэг эх нь орлоготой, мөнгөтэй, хүүхдээ хамгаалах төсөвтэй байж байж явахгүй бол одоо яаж байна. Ихэнх нь гэр бүлийн хүрээнд эцэг эх нь ажилгүй, архидалттай иймэрхүү байдал болоод байхад бид аливаа юмыг уг үндсээр нь шийдмээр байна. Тэгэхээр энэ дээр Булгантуяа сайд аа, та ямар нөгөө л хуучин бодлого, нөгөө л хуучин зорилтууд тавиад л ороод ирээд байна. Гэтэл энэ нөгөө эрэлт хэрэгцээнд үндэслэсэн эмэгтэйчүүд, залуучууд яг тэр сегмент рүү чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжээд, тэгээд тэр айлын орлогыг нэмэгдүүлэх чиглэлийн зүйлүүд дээр яг энэ төсөв энэ юу энэ тэр харахад харагдахгүй байгаад байна л даа. Тэгэхээр энэ дээр ямар бодлого барих ёстой вэ. Энэ дээр Сангийн яам нь ч гэсэн энд сууж байна. Бид яг үнэндээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж л ажлаа хийхгүй бол ямар ч хүн энд ажлын байр ядуурал, ажилгүйдэл ядуурал бол буурахгүй байгаад байгаа шүү дээ. Өндөр байгаад байгаа. Тэгээд энэ дээр төсөвлөгдсөн юм нь ингээд 9 хувиар буураад ороод ирчихсэн гэж байна. Өмнө болохоор тэр асар их мөнгө зарцуулсан хэр нь ихэнх нь сургалт семинар гэдэгт явжээ гэсэн дүгнэлтийг Аудитын газраас хийчихсэн байна л даа. Тэгэхээр яах ёстой вэ? 2024 оны төсөв дээр яг энэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ийм ийм зүйлүүдийг ийм төсөвт тусгаад ийм ажлын байрыг энэ чиглэл салбарт бий болгох энэ бодлогоо бид Засгийн газар дээр хамгаалаад төсвөөрөө ингэж орж ирж байгаа гэсэн хариултыг надад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан маань өгөөдхөөч. Нэгд энэ асуулт байна.

2-т нь, Чинзориг сайд өөрөө бас дөнгөж сайд болсныхоо дараа ч өөрөө бас хэлж байсан. Тэр Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг үр дүнтэй болгохгүй бол бид асар их хөрөнгө мөнгө нэмээд л байдаг үр дүн

байхгүй. Сая энэ Аудитын газрын дүгнэлт дээр ч гарч байна шүү дээ. Одоо ингээд бид нар харахад 2022 онд л гэхэд ӨЭМТ, сумдын ЭМТ гэх мэт энэ зардлууд 21 онтой харьцуулахад 78 тэрбум төгрөгөөр буюу 26 хувиар өсчихсөн. Үүнийг 20 онтой харьцуулахад 365 тэрбум төгрөгөөр буюу 30 дахин өссөн. Жишээ нь, өрхийн эрүүл мэнд. Эмийн сангуудад олгож байгаа санхүүжилтийг аваад үзэхэд 88 тэрбумын санхүүжилт олгосон 21 онтой харьцуулахад 28 тэрбум төгрөгөөр буюу 44 хувиар, 20 онтой үүнийг харьцуулаад үзэхэд 2 дахин нэмэгдсэн. Гэтэл яасан, эмийн үнэ нэг их дорвитой буурдаггүй, буур ... /минут дуусав/

**П.Анужин:** Эхлээд хариултаа авчхаад тодруулъя гэсэн үг. Оюунчимэг гишүүний асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа хариулна.

**Х.Булгантуяа:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Тантай бол санал нэг байна. Манай халамжийн зардал дээр хүүхдийн өсөлт яг органик өсөлтөөрөө хүүхдийн мөнгөний дүнг бол нэмээгүй шүү дээ. Зүгээр хүүхдийн дүн өсөж байгаа холбоотойгоор нийт дүн өсөж байгаа холбоотойгоор мөн 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс халамжийн сангаас бол тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлж байгаатай холбоотойгоор, мөн 07 сарын 01-нээс төсвийн тодотголоор нэмэгдсэн нэмэгдэлд бас нэмж орж ирээд халамж бол нэмэгдсэн дүнтэй харагдаж байгаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энэ ажлын хүрээнд бид нар ерөөсөө 1 дүгээрт, бас түрүүний Баярсайхан гишүүний хэлж байгаатай адилхан хүн амын нэгдсэн өсөлт хөгжлийн нэгдсэн бодлоготой байх ёстой гэдэгтэй яг адилхан хөдөлмөрлөлтийг дэмжсэн нэлээн томоохон бодлого, тооцоо судалгаа зайлиггүй шаардлагатай байгаа. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тоймтой судалгаа байхгүй байгаагаас үүдээд хэдийгээр бид

нар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Боловсролын зээлийн сан, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд жил болгон бид нар санхүүжилт олгож явж байгаа ч гэсэндээ харамсалтай нь ажилгүйдэл дорвитой бууж өгөхгүй, ядуурал бас дорвитой бууж өгөхгүй байна. Үүнтэй холбоотойгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бараг өмнөх нь 10 гаруй жилийн өмнө хийгдсэн байсан хөдөлмөрийн зах зээлийн томоохон судалгааг бид нар хийж байна. Ингэж бид нар аймаг, орон нутаг руу, дээрээс нь нэмээд улсаас хөдөлмөр эрхлэлт, боловсролтой холбогдож олгогдож байгаа зээлүүдийг хөдөлмөрийн зах зээлтэйгээ уялдуулж бид нар олгохоор бид нар юу яаж байна. Дээрээс нь нэмээд шаардлагатай тохиолдолд сургалтууд хийнэ. Тэгэхдээ шаардлагагүй сургалтуудад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон бусад олон улсын төслүүдийн санхүүжилтүүдийг гаргаад байдаггүй, байгаа оносон ийм бодлогыг хийхийн тулд бид нар ийм судалгааг хийж байна. Энэ судалгааны үр дүнг Нийгэм бодлогын байнгын хороондоо энэ оны сүүлээр бид нар танилцуулна гэж бас харж байна.

Ялангуяа халамжаас, хөдөлмөрт гэх юм бол ерөөсөө л хамгийн чухал нь сүүлийн арваад жилийн манай хөдөлмөрийн зах зээлийн тоон мэдээллийг Дэлхийн банкны юугаар жил болгон гаргадаг. Тэгэхэд сүүлийн хориод жилд шинээр бий болсон ажлын байрны 60 гаруй хувь нь дундаж болон дунджаас доош цалинтай ажлын байран дээр, дээшээ өндөр цалинтай ажлын байран дээр бол дандаа л шилжих хөдөлгөөн явагдаад байгаа болохоос биш шинээр ажлын байр гарах нь бол бага байна. Хамгийн өндөр хөрөнгө оруулалттай уул уурхайн салбар бол нийт хөдөлмөрийн зах зээлийн тав арваны тавхан хувийг шингээж байн гэсэн хөдөлмөрийн салбарын бол бас нэлээдгүй ийм анхаарах ёстой тоо баримтууд гарч байгаа. Тэгэхээр бид нар ирэх онд манай Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн

орлого бол нэлээдгүй буурах шинжтэй байгаа.

Ялангуяа аялал жуулчлалыг дэмжих жил. Үүнтэй холбоотойгоор зарим үйлчилгээний салбаруудад гадаадаас авах хүчин асуудлыг хүртэл шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд бас салбарын сайд нар ярьж байгаа. Ингэнэ ээ гэх юм бол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого бас нэлээдгүй буурна гэсэн үг. Харин үүнтэй холбоотойгоор тэгвэл бид нар дотоодынхоо хөдөлмөр эрхлэлтийг хэрхэн яаж дэмжих вэ гэдэг дээр энэ судалгааны үр дүнг харж байгаад Нийгмийн бодлогын байнгын хороон дээр Оюунчимэг гишүүнд ч гэсэндээ тусгайлан энэ судалгааны тоон мэдээллийг бас танд хүргүүлбэ.

**П.Анужин:** Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг гишүүн Оюунчимэг гишүүний асуултад хариулна. Түүрүүнээс хойш Чинзориг сайдын микрофон асуудалтай байгаад байна. Ажлын хэсэг анхаараад өгнө үү? Чинзориг сайдын микрофон нь ажиллахгүй байгаад байна.

**С.Чинзориг:** Оюунчимэг гишүүний асуулт хариулъя. Эмийн үнэтэй холбоотой асуудал бас жаахан асуудалтай байгаа нь үнэн. Чанарын асуудал ч бас байна. Би сайд болсноос хойш эмийн үнэтэй холбоотой асуудал дээр бас 2 бас өөрчлөлт хийхийг яасан бас шийдсэн. 1дэх асуудал нь даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр өгдөг эмийн хөнгөлөлтийг бол нэлээн бууруулчихсан байсан. 70 хувийн хөнгөлөлттэй эмийг 50 хувиар, 50 хувийн хөнгөлөлттэй эмийг 30 хувийн хөнгөлөлттэй өгдөг байсныг 05 сарын 01-нээс эхлээд 70 хувийн, 50 хувийнх нь хөнгөлөлтийн хэмжээнд бас хүргэж өгч байгаа. Энэ бас ахмадуудад хүрч байгаа. Энэ хэмжээний дараагаар ялангуяа ахмадуудын зүгээс бол эмийн үнэ өндөр байна гэдэг үг хэл нэлээн бас багассан гэж бодож байна.

2 дахь асуудал нь хөдөөгийн багийн ахмадууд хөнгөлөлттэй эмийг авахын тулд зайлиггүй сар болгон сумын төв шогшиж орж байж, хурууны хээгээ уншуулж авдаг байсан. Энэ жоохон хүндрэлтэй байна гээд заавал сумын төв орж хурууны хээ уншуулахгүйгээр багийнхаа эмчийн жороор бас эмээ авдаг болгосон. Энэ бас хөдөөгийн багийн иргэдэд чирэгдлийг бас бууруулсан арга хэмжээ болсон.

2 дахь асуудал нь хаврын чуулганаар манай гишүүд мэдэж байгаа. Төрийн болон орон нутгийн өмчийн өмчийн хөрөнгөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал дээр шинэчилсэн найруулга дээр горимын санал гаргаж байгаад олон улсын стандарт чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг бол гадаад улсын үйлдвэр үйлдвэрлэгчээс нь болоод олон улсын худалдан авалтын системийг ашиглаж шууд худалдан авдаг байх гэсэн ийм заалт оруулсан. Энэ ингээд энэ хууль 12 сарын 01-нээс хэрэгжинэ. Одоо бид нар юу хийх ёстой вэ гэхээр энэ үйлдвэрлэгчээс нь болоод тэр олон улсын худалдан авалтын систем шууд худалдан авах, хийдэгтэй холбоотойгоор журмаа бид Засгийн газар руу оруулна. Ингэж чадах юм бол бас нэлээн ахиц өөрчлөлт гарах болов уу гэж л бодож байгаа. Үнэ чанар дээр.

Би эхний ээлжид юу бодож байна вэ гэхээр төрийн эрүүл мэндийн байгууллагуудын авч байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа эмийг эхний ээлжид энэ шууд худалдан авалтын аргаар хийдэг болгоё гэж. Ингэвэл энэ эмийн үнэ чанартай холбоотой асуудал дээр жаахан өөрчлөлт гарах болов уу гэж.

2 дахь асуудал нь эмийн тендер дээр хэмнэлтийн зарчим үйлчлэхгүй. 2 дахь асуудал нь эмийн тендер дээр бага үнийн санал бас үйлчлэхгүй гэдгийг бас

тэр хуульд бол оруулж өгсөн. Одоо Сангийн сайдын журам гаргах ёстой. Бид нар эмийн тендер дээр зөвхөн чанар ба үнийн хосолмол шалгуураар эмийн тендерийг дүгнэдэг болно гэсэн. Тийм учраас энэ чиглэлээр бас Сангийн сайдын тушаал гаргана гэж бодож байгаа. Миний бодож байгаагаар 100 хувь байлаа гэхэд эмийн чанартай холбоотой асуудал нь 70 хувь, үнэтэй холбоотой асуудал нь 30 хувийг нь бас эзэлдэг байхаар ийм шалгуурыг нь бас гаргаж энэ журмыг нь батлуулна гээд ийм бас цогц арга хэмжээнд авбал энэ эмийн үнэ, чанартай холбоотой асуудал жаахан өөрчлөлт гарах болов уу гэж.

2 дахь асуудал. Бид нар эм, эмнэлгийн хэрэгслийнхээ тухай хуулийн төсөл дээр бол ажиглаж байгаа. Удахгүй чадвал ингээд намрын чуулганаар хэлэлцүүлж гэсэн ийм бодолтой байна. Энэ дээр бас манай гишүүд илүү анхаараад дэмжээд өгвөл бас жаахан өөрчлөлтүүд хийе гэсэн ийм санаа байгаа.

Манай дээр нэг дутагдаж байгаа юм энэ эмийн лабораторитой холбоотой асуудал, чанарын хяналт баталгаажуулалт хийдэг лабораторийн хүчин чадал бас муутай гэдэг асуудал байгаа. Үүнийг бид нар энэ Дэлхийн банкны төслөөр ковидын дараах хариу арга хэмжээний хүрээнд Ковидын сангийн төслийн хүрээнд бас төсөл бичээд төсөл дэмжигдсэн. Тэндээс нэг 5 тэрбум төгрөгийн төсөл он гараад бол хэрэгжинэ. Энэ хөрөнгө мөнгөөр нь агентлагийн харьяа лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх ийм бас арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа. Ингэвэл энэ эмийн чанарын хяналт баталгаажуулалттай холбоотой бас нэлээн бас ахиц гарах болов уу гэж бол бодож байгаа.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

**М.Оюунчимэг:** Чинзориг сайдад итгэж байгаа. Энэ эмийн мафийнхаа өмнө ноён нуруу хугарахгүй байгаасай л гэж их бодож байна. Яагаад гэвэл жишээлбэл эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудын 72,9 хувийг нь эмийн сангууд эзлээд байгаа юм. Ийм их мөнгө тийшээ урсаж байна шүү дээ. Тэгээд бид нар төсвийг нь 2 дахин, 3 дахин нэмж өгөөд байдаг 20 онтой харьцуулахад. Гэтэл иргэд эмийн санд үнэ нь огт буурахгүй, үйлчлэхгүй, тэгээд энэ дээр хамгийн их гомдолтой байна. Уулзах болгонд. Тэгээд бид энэ дээр өөрчлөлт хийхгүй бол нэг хэсэг хүмүүсийг тэжээх гэж төсвөөс ингэж мөнгө явуулаад байж болохгүй л дээ. Энэ бол авлига бас хууль бус мөнгө угаалт энэ тэр явж байна гэж ойлгож болохоор байгаа шүү дээ. Тэгээд ийм Чинбүрэн гишүүнээр ахлуулсан манай ажлын хэсэг байгаа. Энэ дээр үнэхээр онцгой анхаарах хэрэгтэй болов уу гэж бодож байна.

Нөгөө талаасаа Булгантуяа сайд аа, та сая яг бас хэлж байна. Нөгөө судалгаа хараад судалгаа дээр үндэслээд дараагийн арга хэмжээ авна гээд. Тэгэхээр Байнгын хорооны дарга аа, минутаа нэгтгээд авчхаж болох уу, дахиад нэг тодотгоод.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнд нэмэлт 1 минут өгье.

**М.Оюунчимэг:** Судалгаа бол байгаа шүү дээ, Булгаа сайд аа. Өмнө Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам маш нарийн судалгаа, Үндэсний статистикийн газар, НҮБ, тэгээд Азийн хөгжлийн банктай хамтраад судалгаанууд хийсэн, тэрийг бас танилцуулж байсан. Тэгээд яг эрэлт хэрэгцээтэй хөдөлмөрийн зах зээл мэргэжлийн Боловсролын яамтайгаа хамтраад энэ дээрээ суурилоод төсөвтэйгөө уяад, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлуудаа шуурхай явуулчихвал яасан юм бэ? Одоо бас судалгаа хийгээд.

Мэдээж яах вэ, нөхцөл байдалтай уялдсан асуудлуудыг та нар хийх байх. Гэхдээ энэ чинь цаг биш. Одоо хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангууд чинь төсөв 1-д байхгүй, 2-т, дүүргүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд яг иргэд ярьж байгаа юм. Бодитоор зээл авсан хүн бараг цөөхөн байна шүү дээ. Тэгэхээр энэ мөнгө хаашаа яваад байгаа юм. Энд бас хяналт энэ тэрээ тавиад үр дүнтэй байхгүй бол үнэхээр энэ ажил, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой энэ асуудал чинь дамнуурах нь л дээ. Тэгээд энэ дээр үнэхээр анхаармаар байна. Тэгээд Сангийн яам заавал энэ тэтгэврийг халамж дээр аваачиж тавьчхаад, халамжийн энэ үзүүлэлт нь ийм өндөр гаргаад байх шаардлага байгаа юм уу?

**П.Анужин:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа Оюунчимэг гишүүний асуултад гүйцээж хариулъя.

**Х.Булгантуяа:** Оюунчимэг гишүүн бараг санал хэллээ. Таны саналыг бол хүлээж авч байна. Дэлхийн банкнаас олон улсын байгууллагуудаас юу бол судалгаанууд гаргадаг тухайн жилтэй холбоотойгоор бол судалгаанууд гаргадаг. Түүрхэн хэлсэнчлэн бид нарын зайлиггүй бодох ёстой асуудал нь үнэнийг хэлэхэд хувийн хэвшил битгий хэл, төр ч өөрөө өөртөө хэрэгцээтэй байгаа хүний нөөцийг бэлдэж чадахгүй байх. Энэ шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд, Алсын хараа 2050-ийг хэрэгжүүлэхэд Монгол улсад ямар мэргэжлийн ямар хүмүүс хэрэгтэй байгаа юм.

Дээрээс нь нэмээд энэ томоохон сэргэлтийн бодлогуудын үр дүнд үйлдвэржилтийн томоохон бодлого, уул уурхайн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулахад бид нар хувийн хэвшилд тэгвэл ямар нарийн мэргэжлийн хүмүүс хэрэгтэй байгаа юм бэ гээд эдгээр хүмүүсээ бэлдэх дээр төр өөрөө бодлогоор хэрэгжүүлэх ёстой. Уг нь бол төрд нэг жилд 1000-аас оргил үедээ 2000 гадаад хуваарь жишээлбэл ирдэг. Түүнийг бид нар өөрсдөө бодлогоороо

өнөөдрийг болтол жишээлбэл, боловсролын салбарт, эрүүл мэндийн салбарт, нийгмийн хамгааллын салбарт ч гэдэг юм уу 1 дүгээрт, гадаадад хувь хүн өөрөө яваад сурахад үнэтэй, 2 дугаарт өөрсдөө, магадгүй хувь хүн бол өөрөө хүүхдүүдээ банк санхүү эдийн засгаар хуульчаар сургаад байдаг байх. Энэ салбаруудыг бол төр өөрөө бодлогоороо энэ хүмүүсээ бэлдэж авах ёстой. Энэ хүмүүсээ бид нар бэлдэж авч чадаагүй. Манайх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн томоохон төвүүдийг 5 аймагт байгууллаа гэхэд тэнд ажиллах нарийн мэргэжлийн хүмүүс дутагдалтай байна. Одоо ахиад бид нар цаана нь 5 аймагт барихаас гадна ахиад 3, 4 аймагт Нийслэл Улаанбаатар хотод байгуулна гэхэд энэ нарийн мэргэжлийн хүмүүсийг төр өөрөө тусгай хэрэгцээт боловсролын багшаас авхуулаад энэ нарийн мэргэжлийн хүмүүсийг бэлдэх зайлшгүй хэрэгцээ шаардлага бол байгаа. Энэ нь олон улсын судалгаагаар бол төдийлөн сайн гарч ирж чадахгүй байж байгаа.

Жил болгон Боловсролын яамнаас гадаадын юунд тэтгэлэгт хөтөлбөрт оруулах мэргэжлийн шаардлагын талаарх яамдаас саналыг авдаг юм. Гэхдээ энэ бол төдийлөн яг үнэнийг хэлэхэд бас сайн болж чаддаггүй. Тэгэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс хөдөлмөрийн зах зээлийн ядаж эрэлт нийлүүлэлтийн тоймтой сайн судалгаатай, Алсын хараа 2050 шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд, дээрээс нь нэмээд хувийн хэвшлийн цаашаагаа 5-10 жил хөгжлөө юу гэж харж байгаа юм гэдэгт тааруулж бид нар энэ олон улсын зээл, тусламж, тэтгэлэгт хөтөлбөр, боловсролын зээлийн сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гэдэг бол татвар төлөгчдийн мөнгө шүү дээ. Тэгэхээр үүнд чиглүүлж бид нар энэ санхүүжилтийг зөв зохистой гаргах нь зүйтэй юм гэж үзэж байна. Тэрнээс биш яг одоогийн байгаа тоон мэдээллээр тооцоо судалгаагаар бол бид нар энэ жил хийсэн юмаа л ирэх жил хийх юм билээ. Тэгээд

таны хэлж байгаагаар бол үр дүн муутай л бодлого болох гээд байдаг байгаа онохгүй.

**П.Анужин:** Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя.

**Ц.Туваан:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас асууя. Энэ өнгөрсөн жил баталсан Нийгмийн даатгалын багц хууль дотор орсон нэг чухал заалт бол энэ малчдын НДШ-ийн 50 хувийг төрөөс даах ийм шийдвэр гарсан. Энэ дээр хэдэн тэр тэрбум төгрөг энэ жил тавигдсан бэ? Давхар бас нэг хууль батлагдсан энэ бас би болон манай гишүүд санаачлаад ингээд явсан. Энэ төрөөс олгох урамшууллаас эрүүл мэнд, НДШ суутган тооцох гээд. Энэ хууль 10 сарын 01-нээс хэрэгжээд эхэлсэн. Сумд байгаа нийгмийн даатгалын байцаагч нартай ярихаар энэ талаар мэдээлэл алга байна. Тэгэхээр нийгмийн даатгалын яг хэрэгжүүлэх байцаагч нар мэдээлэлгүй байгаа юм чинь тэр малчид дээр бол мэдээлэл очоогүй байгаа нь тодорхой. Тэгэхээр энэ хуулиудаа сурталчлах зардал дээр танай яаман дээр яг ирэх жилийн төсөв дээр хэдэн тэрбум төгрөг хууль сурталчлах зардал дээр тавьсан бэ гэдэг ийм асуулт.

Нэрийн дансны асуудал дээр яах вэ, энэ 27 их наяд хүрээд явж байгаа байхгүй юу. Энэ мөнгө. Ямар ч мөнгө байхгүй. Тэгээд энэ жилээс яах вэ, энэ нэрийн дансаа мөнгөжүүлэх энэ эхний алхмууд хийгдэж эхэлж байгаа. Тэгэхээр энэ 380 тэрбум төгрөгөөр 20 хэдэн их наядыг гүйцэх бол боломж байхгүй. Тэгэхээр үүнийг юу яамаар байна, ямар бодлого гаргаж явах юм бэ. Энэ чинь хурд нь гүйцэхгүй шүү дээ. Тэгэхээр тэр энэ дээрээ энэ мөнгөжүүлэх дээрээ эхэлсэн энэ ажлаа яаж түргэн явуулах вэ гэдэг ийм асуулт байна.

Энэ салбарт чинь ажиллаж байгаа хүмүүс байгаа. НДЕГ, Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар, хүүхдийн асуудал, сэргээн засал гээд. Энэ

ажилд яг ажиллаж байгаа хүмүүсийн чинь нийгмийн асуудалд та ер нь энэ жил ирэх жилийн төсөв дээрээ мөнгө тавьсан уу? Энэ хүмүүс чинь хувцас хунар, сургалт, нийгмийн асуудлууд гээд асуудал дээрээ нөгөө загасчны морь усгүй гэдэг шиг үлдээд байгаа юм. Энэ хүмүүс дээрээ хэдэн төгрөг тавьсан бэ гэдэг ийм асуултыг асууя.

Эрүүл мэндийн сайдаас Төв аймгийн Эрдэнэ сумын ЭМТ-ийн барилгын төсөв энэ жилдээ ингээд хүрээд дуусчхаж байгаа юу? Түүн дээр үлдэгдэл байгаа, байхгүйг нь би бас энэ дээр сайн харагдахгүй байна.

2 дугаарт нь, энэ Баян, Баяндэлгэр гээд сумд хэдэн жил болж байна аа? Нөгөө жагсаалт гэж ярьдаг юм, эрэмбээрээ бол 1, 2 номерт орчихсон гээд ярьдаг. Төсөв рүү ингээд аймгаас хүсэлтүүд нь явдаг. Энэ барилга нь бол үнэхээр муудчихсан. Тэгээд энэ асуудлууд яагаад орж ирээгүй юм бэ? Энэ талаар Эрүүл мэндийн яамнаас хариулт авъя.

Тэр Ланд Круизер 77 гээд, бид нар энэ хаана ч бараг хэрэглэхээ больж байгаа. Зарим газар энэ хүнд өвчтэй хүмүүс түргэн дуудчихаад өөрсдийнхөө унаагаар тэр фургон, 69-ийг чинь дагаад явж байгаа тохиолдлууд байгаа шүү дээ. Тэгэхээр үүнийг бид нар бол халах цаг болсон. Одоо тэр Монгол Улсын эдийн засаг бас нэг үеэ бодвол сайжирсан шүү дээ. Тэгэхээр яг тэр шаардлагатай Ланд круизер 77 машинаар хангах асуудал бас яригдаж байгаа юм байна. Тэгэхээр энэ дээр нэг боломж байвал ямар үнэтэй байдаг юм бэ? Энэ машины үнийг нь надад нэг хэлээд өгөөч.

Эмийн үнэ дээр бол ахмадуудын маань тэтгэврийн хамаг мөнгийг энэ эм аваад явж байгаа. Тэгээд бид нар түрүүн сая Чинзориг сайдын хариултад тэр хууль энэ тэр батлаад өгсөн, энэ Сангийн сайд дээр журам нь гагцхиад байгаа юм байна. Ингээд юмаа хурдан хэрэгжүүлмээр байна. Үүнийг худалдан

авалтаа хийж, тэр эмийн үнээ буулгах асуудал дээрээ маш яаралтай шийдвэрээ гаргахгүй бол хуулийн өөрчлөлт нь гараад оччихсон байдаг. Ингээд хэрэгжихгүй байгаа асуудлууд байгаа юм байна. Тэгэхээр энэ дээр ямар бодлого байна?

Тэр хүүхдийн шүд, хүмүүсийн шүд цооролттой холбоотой асуудал дээр энэ урьдчилан сэргийлэх ажлууд байгаа шүү дээ. Тэр нөгөө нэг фтор түрхэх ч байдаг юм уу, эс үгүй бол нөгөө нэг ам зайлдаг шингэн ч юм уу, энэ дээр тавигдсан төсөв байна уу. Үүнийг нэг хэлээдхээч. Энэ ... /минут дуусав/

**П.Анужин:** Туваан гишүүний асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа хариулъя. Дараа нь Эрүүл мэндийн сайд хариулна.

**Х.Булгантуяа:** Нийгмийн даатгалын багц хууль шинээр батлагдсантай холбоотойгоор 2024 оны төсөвт хэд хэдэн шинэ арга хэмжээ төсвийн суугдсаны нэг нь бол малчны НДШ-ийн асуудал байж байгаа. Үүнд 2024 оны төсөлд нийтдээ 25 тэрбум төгрөгийг суулгасан. Энэ бол 50 хувийг нь малчин өөрөө төлөх зайлиггүй шаардлагатай байгаа. Тэгэхээр малчин төлөх юм бол улсаас төлнө өө гэсэн үг.

Мөн үүнтэй холбоотойгоор Туваан гишүүний өргөн барьсан малчдад олгодог урамшууллаас бас үүнийг малчин төлөхөөр бас энэ хууль, эрх зүйн орчныг бид бас хийж өгсөн байж байгаа. Арьс ширний урамшуулал, ноос ноолуурын, сүүний урамшуулал гэх мэтчилэн урамшууллыг малчдад олгодог.

Мөн ирэх оноос бас нэг бид нар бас энэ хуулийн сурталчлах зайлиггүй шаардлагатай байгаа нь байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхчүүдийн эцэг эсхүл эхийн тэтгэврийн шимтгэлийг улсаас даадаг болж байгаа. Ирэх онд. Үүнтэй холбоотойгоор бас

санхүүжилт нь бас манай төсөвт бас суугаад явж байгаа.

Ирэх онд, одоо таны хэлж байгаа бол үнэн. Нөгөө загасчны морь усгүй гэгчээр юу нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын асуудал хариуцсан манай салбарынхны цалин бол маш бага. Бараг хүүхэд хамгаалал, нийгмийн даатгалын ажилтны цалин маш бага байсан. Сая 07 сарын 01-нээс 30 орчим хувиар бол нэмэгдсэн. Ирэх онд 04 сарын 01-нээс ахиад 10 хувиар нэмэгдэнэ. Мөн аймгийн төвд, аймгийн төвийн сумдад ажиллаж байгаа, мөн захын 3 дүүрэгт ажиллаж байгаа албан хаагчдын цалин 20 хувиар, сумдад ажиллаж байгаа албан хаагчдын цалинг нэмж 40 хувиар нэмэхээр байж байгаа. Мөн ТЗ 5 жил тутамд авдаг 5 жилийн нэмэгдэл, 6 сарын нэмэгдлүүдийг бас ирэх онд олгохоор төсөвт бас бид нар суулгаж өгсөн байж байгаа.

**П.Анужин:** Сангийн сайд Жавхлан уг асуултад нэмэлт хариулт өгнө.

**Б.Жавхлан:** Туваан гишүүний асуултад нэмэлт мэдээлэл шүү, мэдээлэл дутуу л байх шиг байна. Тэр саяын тэр журам чинь манай дээр гацаад байгаа юм байхгүй. Хууль нь 12 сараас хэрэгжиж эхэлнэ. Тэр болтол журам наана нь гарах байх. Манайд тэр журам нь байгаа гэсэн болохоос биш гацсан гэж хэлээгүй. Тийм, хууль нь хэрэгжиж эхлэх хугацаа нь болоогүй байгаа, тийм, гацсан гэж хэлээгүй. Ер нь манай сайд чинь ерөөсөө маш үг үсэг дээрээ хүртэл их маш их нарийн чанга шүү дээ. Тэгээд хэзээ ч алддаггүй. Тийм. Манай дээр боловсруулагдаж байгаа л гэж мэдээлэл өгсөн. Түүнээс гацсан гэж ерөөсөө байхгүй.

**П.Анужин:** Булгантуяа сайд асуултад гүйцээж хариулъя.

**Х.Булгантуяа:** Туваан гишүүн маш чухал асуудлыг бас хөндөж байна. Энэ өмнө нь энэ малчдын шимтгэлийг,

тэтгэврийн шимтгэлийг нөхөж төлөх тухай хууль 2 жил дараалж хэрэгжсэн. Үүний үр дүн тэгэхдээ хамрагдалт бол бага байсан. Гол шалтгаан нь ерөөсөө иргэдэд энэ мэдээлэл хүрдэггүй. Одоо ч гэсэндээ Монгол Улсын 3,4 сая хүний 1,3 сая орчим нь шимтгэл төлж байна, татвар төлж байна. Тэгэхээр энэ шинэ хууль хэрэгжсэнтэй холбоотойгоор сурталчилгааны ажлыг бид нар нэлээн хийж, хамрагдалтыг нэмэгдүүлэхгүй бол хамрагдаж байгаа цөөхөн хүн дээр татвар ч гэсэн дээ, ерөнхийдөө ачаалал ирээд байна гэдэг ийм бухимдал иргэдийн зүгээс маш их байдаг. Тэгэхээр малчдын НДШ ч гэсэн адилхан энэ нийт манай малчдын 25 орчим хувь нь шимтгэл төлж байгаа. Өөрөөр хэлбэл энэ хүмүүс малчид бол 5 жилээр наана тэтгэвэрт гардаг. Ингээд хэрвээ тэтгэврийн нас хүртлээ НДШ төлж, ямар нэгэн байдлаар нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх нь үүсэхгүй бол халамжийн тэтгэвэр авна гэсэн үг. Тэгээд энэ бол улс жилийн төсвөөс ахиад л татвар төлөгчдийн мөнгөнөөс гарна гэсэн ийм хуулийн одоогоор бол зохицуулалттай байж байгаа. 325 мянган төгрөг. Тэгэхдээ бас манай иргэд маань бас энэ тооцооллыг та бүхэн маань хийгээд үзэх юм бол эмэгтэй хүн дунджаар одоо бол 22 жил тэтгэвэрт гараад тэтгэвэр авч байгаа. Эрэгтэй хүн дунджаар 16 жил авч байгаа. Дундаж Монгол хүний наслалт жил болгон уртсаж байгаа. Эмэгтэй хүний дундаж насаар тооцоод аваад үзэхэд та 325 мянган төгрөгийн халамжийн тэтгэвэр авах уу, 550 мянган төгрөгийн бүрэн тэтгэврийн ядаж доод хэмжээгээр авах уу гэдэг энэ 2-ын зөрөө бол 22 жилээр тооцоод үзэхээр бараг 60 сая төгрөгийн зөрөөтэй байдаг. Тэгэхээр тэтгэвэрт гарсан танд 60 сая төгрөг илүү хэрэгтэй юү, үгүй юү гэдэг энэ өнөөдөр шийдвэрийг л хөдөлмөр эрхэлж байх цаг үедээ та бүхэн маань гаргаж, бид энэ хуулийн сурталчлах ажил дээр ирэх оноос Нийгмийн даатгалын багц хуулиар 2 хувийн зардал буюу ирэх онд 600 орчим сая төгрөгийг бид нар хуулийн

сурталчилгааны ажилд зарцуулахаар болсон. Манай дээр журмууд 58, 9 журам шинэчлэн батлагдахаар байгаа. Энэ журмууд нь бол эхнээсээ зарим нь Засгийн газраар, зарим нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр орж батлагдаад бас ингээд явж байгаа. Тэгээд сурталчилгааны сургалтын ажлуудыг бол хийж байгаа. Тэгэхдээ журам шинэчлэгдэн батлах тусам бид нар шинээр хийх бол хэрэгцээ шаардлага байгаа бүгд хэлчихсэн.

**П.Анужин:** Булгантуяа сайд сая маш чухал асуултад маш тодорхой тоо, судалгаатай хариуллаа.

Тэгээд энэ асуудлаа бас энэ өөрөөр хэлбэл Нийгмийн даатгалын багц хуулийг нийтэд танилцуулахын төлөө 600 орчим сая төгрөг төлөвлөөд, бид нар хууль сурталчлах ажлаа хийнэ ээ гэж байна. Энэ маш чухал асуудал болов чиг энэ яамд өчнөөн контент хийдэг. Хууль сурталчлах, нийгмийг соён гэгээрүүлэх, наад контенцыг чинь үзээд хэн гэгээрээд байгаа юм бэ гэдэг л асуудал байгаа шүү. Тэгэхээр энэ асуудал дээрээ 600 сан сая төгрөг төлөвлөхөөд энэ хуулийг чинь хэн ч ойлгохгүй, эргээд л яахаараа ийм мөнгө төлдөг юм бэ гээд ингээд орилоод, ингээд ийм асуудал үүсээд байвал энэ бол асуудал шүү. Тэгэхээр энэ контент бүтээх тал дээрээ бас анхаарна биз дээ.

Эрүүл мэндийн сайд асуултад хариулъя.

**С.Чинзориг:** Туваан гишүүний асуултад хариулъя. Төв аймгийн Эрдэнэ сумын ЭМТ-ийн барилга 23 онд төсөв нь тавигдсан. Ингээд барилга угсралтын ажил нь бүрэн дууссан. Одоо Улсын комисс ажиллаж хүлээж авах гэж байгаа юм. Удахгүй комисс ажиллаад хүлээж авах болов уу гэж бодож байна.

24 оны улсын төсөв дээр Баян, Баяндэлгэр сумын ЭМТ-үүд шинээр барих асуудал ороогүй байгаа.

Тэр машинтай холбоотой асуудлыг ер нь би тантай санал байна. Бид бол олон жил энэ ОХУ улсад үйлдвэрлэх Уаз-469, фургон машины түргэний алсын дуудлагад ашиглаж байсан. Энэ бол үндсэндээ тийм хүнд өвчтөн, хэвтрийн өвчтөн тээвэрлэх зориулалттай ийм машин бол бас биш.

2 дугаарт, сүүлийн үед бас чанар нэлээн муудсан юм шиг байгаа юм. Маш богино хугацаанд чанаргүй болдог, ажил гүйцэтгэх чадваргүй болдог учраас солих ёстой гээд. Тэгээд ингээд бид нар энэ Дэлхийн банкны ковидын төслийн үлдэгдэл хөрөнгө мөнгөөр энэ түргэний унааг шинэчлэх ийм санал Дэлхийн банкттай ярьж байгаа. Би болгоомжлоод нөгөө Улаанбаатар хотын ногоон автобус шиг юм болчих байх гэж айгаад яаман дээрээ бид нар энэ төслийн нэгж тендерийг нь зарлахгүй. Дэлхийн банкттай яриад Дэлхийн банк өөрөө тендерийг нь зарлана. НҮБ-ын худалдан авалтын системээр энэ түргэний унааг авах тендерийг зарлаж, НҮБ-ын худалдан авалтын системээр энэ машинууд зүгээр авч өгөхөөр бол ажиллаж байгаа. Би яг одоо машины үнийг нь хэлэх боломжгүй. Зүгээр миний авсан мэдээллээр бол нэг машин дунджаар 160 орчим сая төгрөг байдаг гэсэн ийм бас тооцоо байгаа. Гэхдээ энэ бас тодорхой хэмжээгээр ядаж хэвтрийн хүнд өвчтөн тээвэрлэх зориулалттай байх, тоноглогдсон байх, амьсгалын аппараттай эд нар байх эд нар гээд бас зохих хэмжээний бас ийм тоноглогдсон машин байх ёстой гэсэн ийм асуудлууд ярьж байгаа.

Тэр эмийн үнэтэй холбоотой асуудал дээр сая Жавхлан сайд ч хэлчихлээ. Тэр хаврын чуулганы батлагдсан хууль чинь бол 12 сарын 01-нээс хэрэгжиж эхлэх юм. Тэгээд тэр хууль хэрэгжих эхлэх хүртэл бид нар Сангийн сайдын тэр гаргах журамд бид ч эмийн үнэ, тендерийн тэр шалгуурын 70 хувь нь чанар байх ёстой, 30 хувь нь үнийн нөлөөлөл байх ёстой гэсэн ийм



саналаа өгч байгаа. Тэгээд Сангийн сайд тэр журмыг батална л гэж хэлж байгаа. Түүнээс Сангийн яаман дээр гагцхиаад байгаа гэж тийм яриагүй. Тэгэхээр Жавхлан сайдын бас болгоомжлоод бас яаралтай хариу өгч байгаа нь ч бас зөв, буруутгах аргагүй зөв л байх.

“Шүд” төсөлтэй холбоотой асуудлыг ирэх жил бол хэрэгжүүлнэ. Би түрүүн хэлсэн Засгийн газар тогтоол гаргасан. Гэхдээ бас нэг болгоомжлол байгаа. Бид нар анх удаагаа ийм “шүд” төсөл Засгийн газрын хэрэгжүүлэх гэж байгаа юм биш юм байна лээ. Өмнө нь миний мэдэж байгаагаар мэдээллээр нэг 4 ч удаа “Шүд” төсөл хэрэгжсэн юм байна лээ. Тэгээд энэ төслүүдийн үр дүн нэг их тааруухан үлдчихсэн. Яг ийм бас дүнтэй болгочих вий гэдэг дээр би маш их бас санаа зовж байгаа. Тийм учраас үүнийг нэлээн сайн зохион байгуулалттай, үр дүнтэйгээр явуулъя гэсэн ийм бодолтой байгаа.

Түрүүн хэлсэн шаардлагатай эмчийг нь бэлдэх шаардлагатай. Тоног төхөөрөмжийг нь бэлдэж өгөх. Нэг хэсгийг нь үнэхээр тэр эмч, боловсон хүчин нь хүртэхгүй бол хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээгээр бас ажиллуулах ийм чиглэлийн юм авна.

Ер нь цаашидаа бид нар энэ нэг бодлого Байнгын хороон дээр ярьж, хууль тогтоомжид өөрчлөлт оруулмаар юм байна лээ. Хөдөө орон нутагт дутагдалтай, шүдний эмч гэхэд ерөөсөө байхгүй. Улсын хэмжээгээр нэг шүдний тусламж үйлчилгээ үзүүлдэг 600 гаруй эрүүл мэндийн байгууллага байна гэсэн ийм судалгаа бол байгаа. Энэ эдгээрийн чинь бараг 90 орчим хувь нь зөвхөн Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж байгаа юм. Улаанбаатар хотод. Тэгээд цаашидаа бид нар үүнийг энэ Улаанбаатар хотод байгаа ажиллах энэ эмийн, шүдний эмч нарт зөвшөөрөл өгөөд байх уу, үгүй юү гэдэг асуудлыг ч

гэсэн тэр бодлоготойгоо ... /минут дуусав/

**П.Анужсин:** Туваан гишүүн тодруулж асууна. Туваан гишүүний микрофоныг өгөөрэй.

**Ц.Туваан:** Тэр эрүүл юу, нийгмийн даатгалын төрөөс олгох урамшууллаас авах зүйл дээр сурталчилгаа энэ тэр явах юм байна. Энэ дээр харин Сангийн яам дээр би бас эртээд мэдээлэл авсан. 70 гаран тэрбум төгрөг бас энэ дээр нэмж тусгаж өгсөн байна лээ. Энэ дээр бол бас талархалтай хандаж байгаа.

Сангийн сайдаас энэ өнгөрсөн жилийн цалингийн нэмэгдэл гээд яриад байгаа. Энэ чинь нөгөө босоо тогтолцоотой байгууллагууд, нийгмийн даатгал, халамж энэ тэр гээд. Эд нарын хүмүүсийн чинь 20 хувийн нэмэгдэл ороогүй. Энэ мөнгө яах юм, ер нь яагаад ороогүй юм бол, энэ жилээс нэмэгдэж орж байгаа юу? Мөн энэ дээр энэ нөгөө ТҮ-ийн төрийн үйлчилгээнд ажиллаж байгаа хүмүүсийн асуудал бас яаж ирэх жилийн төсөв дээр тусаж байгаа вэ гэсэн нэг ийм асуулт байна.

2 дугаарх нь, энэ тусгай зориулалтын шилжүүлэг гэдэг юмыг бас байхгүй болгосон. Тэгээд энэ дээр энэ шилжүүлэг байхгүй болсон ч гэсэн одоо яаж яваад байгаа юм бэ? Дахиад бас нэг ... /минут уусав/

**П.Анужсин:** Асуултад Сангийн сайд Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Туваан гишүүний асуултад хариулъя. Саяын таны яригдсан асуултууд чинь ер нь бүгд шийдэгдсэн юм байгаа шүү. Босоо ч бай, хэвтээ ч бай бүгд нэмэгдэлдээ орж байгаа. Тэр бүү хэл ТҮ-ийнхэн орох орохдоо нэмэгдэж байгаа хувь нь өөр байгаа. Өндөр байгаа. 20 хувиар нэмэгдэж байгаа. Энэ цалингийн нэмэгдэл буюу тэр тэтгэвэр тэтгэмжийг хүртэл бид чинь хуульчлаад

жил бүр инфляцтай уялдуулж нэмнэ гээд оруулчихсан. Тэгвэл яг цалин дээр бол ТҮ-ийн ажилчид 20 хувиар нэмэгдэж байгаа, инфляцтай уялдуулж шүү. Энэ нэмэгдсэн суурин дээрээсээ дахиад орон нутгийн нэмэгдэл нь аймгийн төв дээрээ 20, сумд 40 гэж авна. Ингэхээр энэ чинь 40 хувь чинь бараг 55 хувь болоод явчхаж байгаа юм. ТҮ дээр бүр бараг 70 хувь, бусад босоо, хэвтээ ТЗ болон бусад төрийн албан хаагч нар дээр бараг 50 гаруй хувь .../минут дуусав/

**П.Анужин:** 2 номерын микрофонд Сангийн яам хариулт өгнө. Гүйцээж хариулт өгье.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Тэгэхээр тусгай зорилтын шилжүүлэг 2013 оноос Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хэсэг хугацаанд бид нар хэрэглэж байсан. Гол зорилго нь бол юу байсан бэ гэхээр босоо тогтолцоо буюу ЭМЯ, Боловсролын яаман дээрээ бөөн дүнгээрээ төсөв нь батлагдаад, аймаг болгонд нь төсвийг нь хуваарилж өгөөд, аймаг нь цаашаагаа сумдаа хуваарилж өгөөд, сум нь байгууллагад нь хуваарилж өгөөд ингээд зарцуулдаг. Өөрөөр хэлбэл тухайн зориулалтынх нь дагуу мөнгийг нь шилжүүлж өгөөд зарцуулдаг ийм тогтолцоо бол байсан. Аймгаар нь дамждаг гэсэн үг.

Одоогийн эрүүл мэнд болон боловсролын салбарын тогтолцоо бол яаж явж байна гэхээр 1 хүүхдэд ноогдох хувьсах зардлаар буюу хэдэн хүүхэд сурч байгаагаар нь хэчнээн хэмжээний чанартай, ямар чанартай, чанарын шаардлага хангасан эмчилгээ үйлчилгээ үзүүлж байгаагаар нь бол эмнэлэгт нь шууд шилжүүлгийг нь өгчхөөд байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл аймгаар нь дамжих шаардлагагүй болчихоод байгаа юм. Тэгэхээр тусгай зориулалтын шилжүүлгийн агуулга Төсвийн хууль дээр байж байгаа. Гэхдээ тусгай зориулалтын шилжүүлгээр дамжиж

буюу аймагт давхар түүн дээр орлогыг нь шилжүүлж өгөх бол шаардлагагүй болчихоод байгаа юм. Гэхдээ гүйлгээ дээр нь бол хяналт тавьдгаараа тавиад явна. Аймгийн Төрийн сан бол хяналтаа тавина. Сангийн яам гүйлгээ дээр нь зарцуулалт тал дээр нь хяналтаа тавиад явна. Баярлалаа.

**П.Анужин:** Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

**Ж.Чинбүрэн:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Эрүүл мэндийн сайдаас хэд хэдэн зүйл асуумаар байна. 1-д, анхан шатын тусламж үйлчилгээ тэр дотроо хүн ам цөөтэй сумдын эрүүл мэндийн санхүүжилтийг индексжүүлэх. Ялангуяа 2500-аас доош 1600 хүн амтай сумдын Эрүүл төвүүдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор бас индексжүүлэх тухай ярьсан. Тэгээд төсөв дээр бол сумын санхүүжилт 391,5 тэрбум төгрөг байхаар туссан гэсэн байна. Тэгэхээр үүнийг тайлбарлаж хэлж өгөхгүй юү? Тэгэхээр бол ер нь нэмэгдэж байгаа гэж ойлгож байгаа. Сая бас Жавхлан сайд ч бас хэлж байна. Ер нь ТҮ-ийн ажилчдын цалин бол багадаа 20 хувиар нэмэгдэж байгаа юм байна. Тэр ч утгаараа Эрүүл мэндийн сайдын багц ямар ч байсан 2 их наядыг анх удаа давж байгаа бас тийм өөдрөг, эрүүл мэндийн салбарт бол нэлээн тийм бодитой санхүүжилт орлоо, орж байгаа ийм төсөв байна гэж харж байна.

Тэгэхээр яг цалин яг ингээд нэмэгдэж байна гэдэг нэг ийм тоо. Тэр дотроо яг эмнэлгийн биш ажилтнуудын цалин нэмэгдэнэ үү, нэмэгдэж байна уу, энэ хэр зэрэг нэмэгдэж байгаа вэ гэдгийг нэг тодруулж өгөөч.

Дараагийн юу бол бид бас бүтээн босголтоо бас хийхээр боллоо. Ямар ч байсан ковид цар тахалтай 2 жилийн хугацаанд хасах индекстэй байсан бол одоо ямар ч байсан Монгол Улсад хэрэгтэй байгаа 3 том эмнэлгийн ажлаа

бол ямар ч байсан урагиллуулахаар ийм орж ирсэнд бол их талархалтай байна. Энэ дээр бол Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах төв, ХСҮТ-2, мөн Зүрх судасны төвийн дэд бүтцийг хийхээр орж байна гэж ойлгосон. Тэгэхээр би энэ зөв гэдэгтээ нэг хариулт авчихъя.

Дараагийн нэг ярих гэсэн зүйл бол энэ эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх чиглэлийн төсвөө хэр зэрэг бодитой үлдээж чадсан бэ? Түүрүүн бас аудитын дүгнэлт байна л даа. Ерөөсөө энэ зорилго, зорилтоо тоогоор илэрхийлэхгүй байна. Тэгээд төсөвт хөтөлбөрүүд нь ямар тоонд хүрэх гэж байгаа, ямар амжилттай хийгдэх юм бэ, хэчнээн төгрөг зарцуулах юм бэ, эдийн засгийн хувьд ямар өгөөжтэй байх юм бэ гэдгийг сайн гаргаж тавихгүй байна гэсэн ийм шүүмжлэлтэй байна. Тэгэхээр бид энэ эрт илрүүлэг гэдэг энэ том санхүүжилт тавьж эхэлсэн. Тэгээд энэ маань ер нь 24 ондоо яаж хэрэгжихээр байна. Би энэ төсвийн задаргааг хараад бол сайн ойлгож чадсангүй. Тэгэхээр та нэг тайлбарлаж өгөхгүй юү? Үүний задаргааг нь хэлж өгөхгүй юү? Нэг ийм асуултууд асууя.

**П.Анужин:** Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг асуултад хариулна.

**С.Чинзориг:** 2024 оны улсын төсөв дээр энэ сумын эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийг, тарифыг нэлээн бас өөрчлөлт хийх нь зүйтэй гэж ингээд Сангийн сайдтай ярьж байгаад нэгдсэн ойлголтод хүрээд, төсөв дээр нэлээн тийм бас боломжийн төсвийн бас төсөл болсон гэж бол үзэж байгаа. Ялангуяа энэ чанар, үр дүнд суурилсан энэ гүйцэтгэлийн аргаар санхүүжилт авахад энэ төвөөс алслагдсан, хүн ам цөөтэй, сумын эрүүл мэндийн байгууллагууд бас үйл ажиллагаа явуулахад жаахан зайлиггүй тарифын тохируулга хэрэгтэй байгаа. 2023 оны 8 сард бид нар үндэсний зөвлөлийн тогтоол гаргаад 08 тоот тогтоол гаргаад бас жаахан

тохируулгууд хийсэн. Газар зүйн коэффициент бас хийж өгсөн.

2024 оны улсын төсөв дээр бүсийн бас коэффициент цоо шинээр бас хийж өгөхөөр төлөвлөж байгаа. Ингэснээр энэ алслагдсан хүн ам цөөтэй, сумын эрүүл мэндийн байгууллагууд хэвийн үйл ажиллагаа явах нөхцөл боломжийг нь бүрдүүлнэ гэж. Энэ бүсийн коэффициент хийж энэ тарифыг бас нэмэгдүүлэхэд 40 гаруй тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр Эрүүл мэндийн даатгалын сан дээр тусгаж өгсөн байгаа. Ингэснээр энэ бас анхан шатын эрүүл мэндийн байгууллагууд нэлээн өөрчлөлт орох болов уу гэж бодож байна.

2 дугаарт, ер нь түүрүүн Сангийн сайд ч хэлсэн. Ер нь төсвийн байгууллагууд эрүүл мэнд гэхгүй төсвийн байгууллагууд чинь цалинг бол ирэх оны 04 сарын 01-нээс нэмнэ. Төрийн үйлчилгээний бага албан тушаалтнуудын цалинг бол 04 сарын 01-нээс 20 хувиар нэмэх, бусад төрийн албан хаагчдын цалинг нь 10 хувиар 04 сарын 01-нээс, орон нутгийн нэмэгдлийг төрийн захиргаа, төрийн үйлчилгээ гэж ялгахгүйгээр гэхдээ төрийн үйлчилгээний бага албан тушаалын ажилтнуудыг ч гэсэн оролцуулаад бүгдээрээ орон нутгийн нэмэгдэл авдаг байхаар төсвийн төсөвт өгсөн.

Харин аймгийн төвийн сумынхан 20 хувийн нэмэгдэл, сумын төрийн захиргаа болоод төрийн үйлчилгээ түүн дотроо тэр төрийн үйлчилгээний ажилтнууд ч гэсэн оролцоод 40 хувийн нэмэгдэл авдаг байх ёстой гэж. Хөдөөгийн албан хаагчтай уулзахад 3 жил 5 жил тутам өгдөг 6 сарын тэтгэмжийг нийт төрийн үйлчилгээний ажилтнууд нөгөө бага албан тушаалын үйлчилгээний ажилтнуудад өгөх ёстой гэдэг шаардлага бол тавиад байдаг. Би үүнийг яг тэр үндсэн мэргэжилтнээ дэмжиж тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого, энэ нь зөв. Энэ нь хэвээрээ байг. Яг тэр үндсэн

мэргэжилтэндээ тэр 6 сарын тэтгэмжээ өгдөг байя.

Харин орон нутгийн нэмэгдлийг эмч, сувилагч, үйлчилгээний ажилтан гэж ялгахгүйгээр орон нутгийн нэмэгдлийг сумд ажиллаж байгаа эмнэлгийн ажилтнуудад бүгдэд нь 40 хувийн орон нутгийн нэмэгдэл өгдөг байх нь зүйтэй гэсэн ийм бас байр суурьтай бол байгаа. Тийм учраас тэр 6 сарын тэтгэмжийг үйлчилгээний бага албан тушаалын ажилтнуудад өгнө гэдэг асуудал энэ төсөв дээр бол яригдаагүй ээ гэдгийг хэлье.

2024 оны улсын төсөв дээр манай гишүүд ч олон жил ярьж байгаа. Чинбүрэн гишүүн ч маш их ярьдаг. Энэ хөрөнгө оруулалттай холбоотой асуудал бол нэлээн бас тусаж байгаа. Энэ нөгөө эдийн засгийг бас ил тод, далд эдийн засгийг ил тод болгож байгаа, энэ нүүрсний хулгайтай Засгийн газраас хийж байгаа энэ бас ажлын үр дүн гэж үзэж байгаа. 2024 оны хөрөнгө оруулалт ,23 оныхоосоо 48 хувиар бол нэмэгдэж байгаа, 48 хувиар бол нэмэгдэж байгаа.

Таны тэр ойлголт бол зөв байна. Эрхтэн шилжүүлэн суулгах төвийг бид нар шинээр барина. Төсөвт өртөг нь 142 тэрбум төгрөг, 24 онд санхүүжих дүн нь 42 тэрбум төгрөг. Хавдрын болоод зүрх, судасны төвүүдийн инженерийн хийцтэй дэд бүтцийг бас хийнэ. Хавдар дээр нэг 13 тэрбум төгрөгийн дэд бүтцийн инженерийн хийцтэй байгууламж барих асуудал байгаа. Зүрх, судасны төвийн барилга нөгөө 3 дугаар эмнэлгийнх нь дэргэд учраас бол арай бага нэг 2 тэрбум төгрөг бол туссан байгаа. Ийм ... /минут дуусав/

**П.Анужин:** Чинбүрэн гишүүн тодруулж асууя.

**Ж.Чинбүрэн:** Тэгээд ер нь ойлголоо. Хариултаа хангалттай авчихлаа. Зүгээр нэмж хэлэх зүйл бол бид бас энэ хөнгөлөлттэй эм дээр нэлээн өөдрөг, дандаа нөгөө инфляцтай

уялдуулаад чанарыг сайжруулна гэсэн утгаараа бол нэлээн санхүүжилт нэмээд байгаа. Үүний хүрээнд бид ард иргэддээ очиж байгаа ачааллыг нэлээн бууруулж байгаа. Одоо бид нарын чухал зүйл бол энэ Их Хурлаас, Нийгмийн бодлогын байнгын хорооноос их анхаарал тавьж ажиллаж байгаа зүйл бол эмийн үнийн өсөлт, түүний чанартай уялдаж байгаа эсэхийг судална. Энэ ажлыг одоо бол ажиллаад эхэлчихсэн. Бид хянан шалгагч нараа томилох ажил маань явж байгаа. Энэ хүрээнд бас түрүүн аудитын дүгнэлтэд бас нэг гарч байгаа зүйл бол ер нь энэ чанартай эмийн платформ, нэгдсэн энэ систем бий болгох, ер нь манай эрүүл мэндийн салбарын нэг доголдоод хийж чадахгүй байгаа зүйл бол энэ цахим шинэчлэлийн асуудал байгаа. Тэгэхээр энэ цахим шинэчлэлийнхээ ажил дээр бас нэлээд анхаарч ажиллах ёстой шүү. Энийгээ бид ... /минут дуусав/

**П.Анужин:** Чинбүрэн гишүүн нэмэлт санал хэллээ. Ахиад бас энэ Байнгын хорооны хуралдаан дээр тодруулж хэлэхэд би бас түрүүн дурдсан Байнгын хорооны хуралдаан хүүхэд хамгааллын сонсгол 2 давхцаж байгаа. Тэгээд энэ Байнгын хорооныхоо хуралд төсөв хэлэлцэхэд бас олон гишүүд маань хуралдаа бас тасралтгүй оролцож байна. Жаргалмаа гишүүн, Сарангэрэл гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа сайд бас энд оролцож байгаа учраас үүнийг бас би тодотгож хэлэх нь зүйтэй.

2 гишүүн бас үг хэлсний дараагаар өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан бараг өндөрлөх болов уу гэж бас төлөвлөж байна. Түүний дараа бас гишүүд маань хүүхэд хамгааллын энэ чухал асуудалд бас оролцоно. Үүнийг бас би тодотгож хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Одоо Бадарчийн Жаргалмаа гишүүн үг хэлнэ, асуулт асууна.

Чинзориг гишүүн бас маш идэвхтэй асуултдаа хариулсаар оролцож байна.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Та бүгдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

**П.Анужин:** Уучлаарай. Жаргалмаа гишүүний микрофоныг эхнээс нь ахиад өгье.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. 2024 оны төсөв хэлэлцэж байгаа энэ цаг мөчид бид нар 2023 онд өөрөөр хэлэх юм бол энэ онд Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөө өргөн барихдаа тойргийн төсөв бус улсын төсөв байя гэдэг зорилт тавьсан. Иргэд олон нийтээсээ саналыг нь авч байж, энэ төсвийг хэлэлцэж байгаа гэдгийг бас онцгойлон хэлье. Яагаад би үүнийг онцгойлж байна вэ гэвэл зөвхөн тойргоо харах бус улсын хөгжлөө харъя гэдэг энэ зорилтоор Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн энэ зүрх сэтгэлээрээ бас энэ төсвийг хэлэлцэж байгаа байх. Би нэг зүйлийг асууя.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ч байгаа хөдөлмөрийн зах зээлийг бид нэмэх, эргээд энэ зах зээлийн уялдаа холбоог холбох, ажлын байрыг бий болгох магадгүй 150 мянган хүний ажлын байрыг бий болгох энэ зорилт тавьсан. Яг өнөөдөр ажлын байрыг бий болгох тал дээр 24 оны төсөвтөө бид нар юу тусгаж чадсан бэ? Булгаа сайд 23 онд ер нь тийм ээ, ажил авснаасаа хойш ажлын байрыг нэмэгдүүлэх тал дээр ямар бодлого барив гэдэг зүйл дээр нэг зүйлийг тодруулъя.

Нөгөөтээгүүр 22 онд Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хянах ажлын хэсэг ажиллахдаа бид нар юунд зорьсон бэ гэвэл ахмадад хүрсэн үйлчилгээг үзүүлье ээ гэдэг ийм зорилтыг тавьж байсан. Хэд хэдэн зорилт тавьсан. Тодорхой хэмжээнд Нийгмийн даатгалын багц хуульдаа бид нар өөрчлөлт оруулж байж чадсан байгаа. Бодитой үр дүн гэх юм бол зүгээр ажлын

хэсгийг ахалж явсан гишүүний хувиар Увс, Хөвсгөл, Эрдэнэт хотод ажиллахдаа жишээ нь Хөвсгөл аймагт Нийгмийн даатгалын хэлтэс нь ажлын байргүй коридорт ажилладаг гэдэг ийм дүн мэдээг бид нар авч ирсэн. Ажлын хэсгээс гаргах тайландаа Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн байгаа. Ажиллах боломжоор нь хангаж өгөөч ээ гэдэг зүйлийг Увс, Хөвсгөл аймгуудад бид нар тавьж байсан. Энэ асуудал төсөвт байхгүй байна. Нийгмийн даатгалын хэлтэс нь ажлын байргүй, ахмадын хөгжлийн төв нь орон байргүй ийм байсан. Тэгээд энэ дээр ер нь ямар арга хэмжээ авсан бэ гэдэг зүйл дээр бас тодруулъя. Өнөрбаяр дарга бол уг нь том амлалт өгөөд ирсэн байдаг.

Нөгөөтээгүүр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал. Энэ аль аль нь шинэчлэгдсэн хуулиудаар бүгдээрээ зохицуулагдчихсан байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, сургалтад хамруулж чаддаггүй хүүхдийн асуудлыг бид нар 3 яамдын санхүүжилтээр шийдвэрлэх хуулийн маань батлагдаад хэрэгжиж эхэлсэн байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхчүүдийг ажлын байртай болгох тал дээр бид нар ер нь төсөвтөө юу тусгаж чадав аа? Бидэнд эерэг мэдээллүүд зөндөө байгаа. Халамжаа нэмж чадсан, хүүхдээ асарч байгаа ижий аав нь тэтгэмжээрээ тэтгэвэр тогтоолгох тэр боломжийг нь бий болгосон. Нөгөө талаар төрийн бус байгууллагуудаа бид бас тодорхой хэмжээнд дэмжих ёстой. Тэгэхээр энэ төрийн бус байгууллагуудаа дэмжих тал дээр бид нар юуг оруулж чадсан бэ гэдэг дээр бас мэдээлэл өгөөч.

3 дугаарт нь, энэ хүүхдийн хүчирхийлэл, амиа хорлолт, үе тэнгийн дээрэлхэлтэд сургуулийн нийгмийн ажилтан бас гол үүрэг гүйцэтгэнэ. Яг энэ тал дээр бас зөвхөн Боловсролын яам гэж орхигдуулалгүйгээр Хөдөлмөр,

нийгмийн хамгааллын яам ямар аргачлал хийж, ямар санхүүжилтийг бид тавьж чадсан бэ? Өөрөөр хэлэх юм бол ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтнуудын асуудлыг шийдвэрлэж чадсан уу. Чинзо сайд аа, бид нөгөөд өсвөр үеийнхний эрүүл мэндийн кабинетыг ЭМТ-үүдэд бүртгэн байгуулах тал дээр бас тодорхой ажил хийх ёстой гэдэг бас асуудлыг ярьж байсан. Энэ асуудал ямар хэмжээнд явж байгаа вэ?

Нөгөө л Жаргалмаагийн ярьдаг асуудал Геронтологийн үндэсний төвийн асуудал. Өнөөдрийг хүртэл шийдээгүй. Ёстой гацаана гэдэг үгийг ид шидээр үзүүлж байгаа. 2011 оноос хойш гацааж байгаа. Хуулийн аль шатандаа явж байна вэ? Шинэ байранд орох ёстой. Өнөөдөр уг нь нээлтээ хийгээд бид нар орно оо гэсэн ийм мэдээлэлтэй байсан боловч өнөөдрийг хүртэл Геронтологийн үндэсний төв шинэ байр луугаа орж чадаагүй байгаа. Өөрөөр хэлэх юм бол түр байр луугаа орж чадаагүй байгаа. Энэ асуудал ямар шатандаа явж байна вэ гэдэг тайлбарыг сонсьё.

Нөгөө талаар бас эмэгтэйчүүдийн бүлгээс анхаарч, Батсүмбэр дэх Ахмадын асрамжийн төв дээрээ очоод бид нар бас нэг замынх нь асуудлыг шийдчихье, уурын зуухны асуудлыг нь шийдчихье, машин техниктэй болгочихъё гэдэг зүйлийг бас Булгаа сайд аа, бид нар тавьж байсныг та санаж байгаа байх. Энэ асуудлаа хэрхэн яаж шийдвэрлэсэн бэ гэдэг дээр бас тайлбар мэдээллийг өгөөч.

Ер нь яг энэ түрүүний Баяраа сайдын хэлсэнчлэн хүний хөгжил рүү чиглэсэн ахмад настнаа дэмжчихсэн энэ бодлого дээр бид нар ер нь санхүүжилтийг хангалттай тавьж чадсан уу гэдэг дээр бас нэг зүйлийг тодруулъя. Нэмэлт нэг дээрээ дараагийнхаас.

**П.Анужин:** Жаргалмаа гишүүн 2 яамтай холбоотой маш олон асуултыг асуулаа. Эхлээд Булгантуяа сайд. Тийм ээ асуусан дарааллаар нь. Яг саяын тавьсан асуудлуудыг шийдэх тал дээр төсөв хөрөнгө тусгасан уу, бодлоготойгоо төсөв уялдаж байна уу гэдэг тодорхой асуулт.

**Х.Булгантуяа:** Жаргалмаа гишүүн чухал асуултууд асуулаа. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор 2020 онтой харьцуулах юм бол хөдөлмөр эрхлэлтийн түвшин ерөнхийдөө бол өссөн тоон үзүүлэлтүүд байгаа. Мэдээж 20 он, 21 он бол ковидын бас хүнд цаг үе байсан. 22 оноос эдийн засгийн сэргэлт гарч 23 онд, 24 онд ч гэсэндээ бид нар бид нар эдийн засгийн сэргэлттэй байна гэсэн бас ийм байдлаар гарлаа. 2020 онд нийт ажилчдын тоо 1 сая 162 мянга байсан бол одоо 2022 оны байдлаар 1 сая 180 мянга гээд нэг 20 мянга орчмоор бол нэмэгдсэн байж байгаа. Энэ бол тэгэхдээ хангалттай тоо бол бас биш. 2021 онд бол ажилгүйдэл 8,1 хувьтай байсан бол 2022 онд 6,7 хувьтай байгаа. Үүнд хамгийн мэдээж төр өөрөө ажил олгогч биш аль болохоор хувийн хэвшлийг дэмжсэн, хөрөнгө оруулалтыг дэмжсэн, экспортыг дэмжсэн, үйлдвэрлэлийг дэмжсэн байж байж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого бол явах ёстой. Үүнтэй холбоотойгоор ялангуяа шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хөдөөгийн сэргэлт, мөн ХАА-н сэргэлт гээд эдгээр бодлогууд бол явж байгаа.

2 дахь асуудал дээр хэн Дамбий дарга тийшээ сууж байгаад 3 дугаар хэсэгт нэмээд хариулчих уу? Хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү гарсан ажлын байрыг дэмжихэд гаргасан зээлийн нийт дүнгийн талаар манай Дамбий дарга нэмээд хариулчихъя.

Сургуулийн нийгмийн ажилчдын хувьд бол цалин нь сая бид нар 2023 оны төсвийн тодотголоор бас нэмэгдэж орж ирсэн байж байгаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд байнгын

асаргаа шаардлагатай хүүхдээ асарч байгаа эцэг хийн тэтгэврийн дадлагын шимтгэлийг төр хариуцах болсон. 2024 онд 11,4 мянган эцэг, эхийн шимтгэлийг төрөөс даахаар 10,4 тэрбум төгрөгийг суулгаж өгсөн. Мөн байнгын асаргааны тэтгэмжийг 2023 оны 07 дугаар сарын 01-нээс 2-3 дахин нэмэгдүүлсэн. 84 мянга орчим төгрөг байсан доод хэмжээг нь 275 мянган төгрөг болгож бас нэмэгдүүлж оруулж өгсөн.

Сургуулийн нийгмийн ажилтны хувьд бол яг бид нарын харж байгаагаар эцэг, эхээсээ гадна хүүхдүүдийн хамгийн их ойр ажилладаг хүмүүс бол багш нар байдаг. Сургуулийн боловсролын салбарынхан байдаг. Дотуур байрны багш нар байдаг. Бид нар 2024 оноос авхуулаад үүнийг бид нар бас хувийн хэвшилтэй, Боловсролын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам бас хамтран хийхээр төлөвлөж байгаа нэг том ажил бол хүүхэд хамгааллын чиглэл рүү сургуулийн нийгмийн ажилтан маань мэдлээ гээд энэ мэдээллүүдийг оруулаад бие биетэйгээ ингээд харилцаа холбоо үүсгэх маань дутуу дулимаг байна гэж Хүүхэд хамгааллын тухай хууль дээр хүүхэд хамгааллын хуулийн энэ хэрэгжилт дээр бас гарсан байж байгаа. Өөрөөр хэлбэл хамтарсан багийн ажлын уялдаа холбоо тааруухан байна. Тэгэхээр бид нар хүүхэд хамгааллын хувийн хэргийг үүсгээ гэдэг нь энэ хувийн хэрэг рүү цахимаар сургуулийн нийгмийн ажилтан, хороодын нийгмийн ажилтан, мөн эрүүл мэндийн ажилтан, цагдаагийн байгууллага, хорооны гэх мэтчилэн хамтраад ийшээ хүүхэд хамгаалалттай холбогдолтой анхаарах ёстой асуудлуудыг логин хийж оруулдаг. Бусад нийгмийн ажилтнууд нь бусад салбарынх нь хардаг. Бүгдээрээ 4, 5 талаас бүгдээрээ үүн дээрээ хамтарсан байдлаар хяналт тавих ийм цахим системийг бий болгохоор бид нар бас оруулж өгсөн байж байгаа.

3 номер дээрээс нэмээд хариулчих уу?

**П.Анужин:** 3 номерын микрофонд өөрийгөө танилцуулаад сайдын хариултад гүйцээж хариулт өгөөрэй.

Сайн байцаана уу. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Дамбий байна. Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой асуулт асуусан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг бид нар санхүүжүүлж явуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг бол шууд дараа жилийнх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих ажилд зарцуулж явдаг. 2016 онд энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого 350 орчим сая төгрөг байсан. Жил ирэх тусам өссөөр байгаад 2021 онд 11,5 тэрбум төгрөгийн орлого орж ирсэн. 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулж тооцдог болсонтой холбоотойгоор энэ орлого буурсан. Тухайлбал тэр онд 2022 онд 4,7 тэрбум төгрөг орсон. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яамнаас бол энэ орж ирсэн орлогоос дандаа илүү хэмжээний хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд жил болгон төсөвлөөд явж байгаа. Тухайлах юм бол өнгөрсөн онд бид нар 11,8 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Ирэх онд 12,2 тэрбум төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд төсөвлөөд явж байгаа.

Төрийн бус байгууллагуудыг дэмжих чиглэлээр бас ажиллаж байна. Энэ хүрээнд бас тодорхой хэмжээний тийм барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх 50 хувийг эргэн төлөх нөхцөлтэй ийм дэмжлэгийг олгодог. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бусад төрлийн

санхүүгийн дэмжлэг зээлд бол эргэн төлөх үйл ажиллагааг, хөнгөлөлтийг үзүүлдэггүй. Зөвхөн хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн ТББ, хувиараа хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхиээлтэй иргэдэд эргэн төлөх нийт дүнгийн 50 хувийг нь хөнгөлөх энэ арга хэмжээг хэрэгжүүлдэг.

ТББ-д олгосон дэмжлэгийн тухайд 17 оноос хойш нийтдээ 1,2 орчим тэрбум төгрөгийг зээл болгож олгосон. Одоо эргэн төлөх үлдэгдлийн дүн бол нэг 500 орчим сая төгрөг байгаа. Эндээс дийлэнх нь хэвийн төлөлттэй явж байгаа. Тэгээд энэ тацрамд бас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаатай холбоотой бас асуудлуудыг асуусан учраас бас нэг зүйлийг тодруулаад хэлчихье гэж бодож байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг төлөвлөхдөө бид нар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж байгаа төсөлтэй хамтраад тогтвортой хөгжлийн зорилгод суурилсан байдлаар төсвийн төлөвлөлтийг хийж байгаа. Энэ дээр бол яг Сангийн яамтайгаа, төслийн нэгжтэй, төслийн нэгжийн дэргэд ажиллаж байгаа зөвлөх багтай хамтарч гэж бид нар энэ тооцоо төлөвлөлтийг хийж байгаа. Ирэх оны төсвийн төлөвлөлтийг хийхдээ сайд, удирдлагуудаас өгсөн чиглэлийн дагуу бид нар тооноос чанарт шилжинэ гэсэн ийм агуулгатайгаар төсвийн төлөвлөлтийг хийсэн. Өөрөөр хэлбэл бага хэмжээний дэмжлэг үзүүлээд үр дүн хангалттай биш гараад байгаа энэ нөхцөл байдлаа сайжруулах, сая аудитынхны дүгнэлтэд ч гэсэн бас энэ зүйлийг түрүү жил бас дурдаж байсан. Үүнтэй холбоотойгоор бид нар цөөн хамаагүй, үр дүнтэй ийм боломжит хэмжээний дэмжлэгийг үзүүлээд ингээд үр дүн гаргана гэдэг ийм байдлаар төсвийг төлөвлөөд үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж байна. Баярлалаа.

**П.Анужин:** Эрүүл мэндийн сайд Чинзориг асуултад хариулна.

**С.Чинзориг:** Тэр Геронтологийн төвийн барилга гээд урт настай, удаан жаргалтай 1 барилга байгаа юм. Жаргалмаа гишүүний хэлдэг үнэн л дээ, 11 онд эхэлсэн. Тэгээд бас хөөрхөн багагүй мөнгө бас гүйцэтгэл авчихсан байдаг. 6 тэрбум төгрөгийн санхүүжилт авчихсан байдаг юм байна лээ. Одоо тэгээд тэр үргэлжлүүлээд бариад ашиглалтад оруулах ямар ч боломжгүй. 1 дэх асуудал нь аудитын дүгнэлт гараад, хийгдээгүй ажилд гүйцэтгэл гараагүй байхад ажилд бас санхүүжилт олгосон байна гэсэн дүгнэлт нэг гарчихсан байдаг юм байна лээ.

2 дахь асуудал нь тэр суурийнх нь ажил чанарын шаардлага хангахгүй байна гэсэн бас дүгнэлт гарчихсан. Тэгэхээр одоо тэр 11 оноос эхлээд одоогийн байдлаар 6 тэрбум төгрөгийн санхүүжилт авчихсан байгаа тэр барилгыг үргэлжлүүлэн явуулах барих ийм боломжгүй. Харин бид нар ингээд АТГ эд нарт материалаа өгөөд шалгуулаад явж байгаа. Өмнө нь ч гэсэн бас Эрүүл мэндийн яамны удирдлагууд бас хууль хяналтын байгууллагуудад ийм хүсэлт өгч шалгуулж байсан. Тэгээд бас тодорхой бас шалгалтын үр дүн бас гарчихгүй л ингээд яваад байгаа юм байна лээ. Одоо бид нар тэр Геронтологийн төвийг өөр барилгад оруулах оруулна гээд ярьж байгаа. Одоо нэг 315 сая төгрөг 24 оны төсөвт туссан байгаа. Түүгээр одоогийн тэр шилжүүлэн оруулах гэж байгаа барилгын гадна дулаан, бохирынхоо асуудлыг хийнэ. Тэрийг нь гүйцэтгэгч компани нь энэ онд хийгээд дуусгачих юм. Он гарангуут нь энэ 24 онд төсөвтөө туссан мөнгөө аваад санхүүжилтээ авчихъя гэсэн ийм байдлаар бол ажиллаж байгаа. Одоогийн бидэнд өгч байгаа мэдээллээр 11 сарын 30 гэхэд ашиглалтад өгөөд дуусна. Тэгээд Геронтологийн төв тэр шинэ байрандаа шилжиж орно гэсэн ийм бас төлөвтэй байгаа.



Таны яриад байгаа тэр өсвөр насныхны кабинеттай холбоотой асуудлыг бид нар тэр Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хууль бас батлагдахаар, нөгөө талдаа ингээд иргэний эрүүл мэндийн боловсролыг дэмжих чиглэлээр нөгөө төлөвлөгөө хөтөлбөр бас батлагдахаар тэр хүрээндээ бас тусгаад хэрэгжүүлээд, шийдвэрлээд явах ийм бүрэн бас боломжтой гэж харж байгаа.

**П.Анужин:** Жаргалмаа гишүүн тодруулъя.

**Б.Жаргалмаа:** Сайд аа, уг нь нэг төр байна, нэг хариуцлага тооцоод хурдхан шиг энэ асуудлаа шийдвэрлэе ээ гээд нэг сайд байх хугацаандаа аль нэг асуудлыг уг нь дуусгачих юм сан гээд зоримоор байгаа юм. Би ч гэсэн энэ танхимд сууж байгаагийнх бас нэг ядаж нэг Геронтологийн үндэсний төв, Ахмад настны хөгжлийн төвөө бас нэг оруулчхаад эндээс буух юм сан гэж бодоод байгаа юм. Тэгээд энэ дээр та бас нэг эрчимтэй ажиллаач ээ гэж хүсэлт тавья. Энэ төр бас нэг хариуцлага тооцох чадвартай баймаар байна. Арвис гэдэг компанитай 6,8 тэрбумыг зүгээр бас өгөөд алдчихмааргүй байгаа юм.

Булгаа сайд аа, Батсүмбэр дээр би нэг хэд хэдэн асуулт тавьсан. Замын асуудал, машины асуудлыг ер нь хэрхэн яаж шийдвэрлэж байгаа. Боловсролын хуулиараа бид нар 3 салбар дундын санхүүжилтийг шийднэ гээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ асуудлыг орхичихсон байгаа. Яг энэ дээрээ бид нар шийдлээ олсон уу. Хуультай болсон хэр нь хэрэгжилт дээрээ бид нар яаж анхаарах ёстой юм бэ гэдэг зүйлийг асуумаар байна. Яг л би жилийн жилд төсөв ярихаараа энэ геронтологийг яриад байгаа юм. Тэгээд энэ уг нь 11 сарын 15-нд нээлтээ хийнэ гэсэн боловч ингээд ажил удааиралтай байгаад байдаг нь юундаа байдаг юм бэ гэдэг зүйл дээр бас нэг тодорхой тайлбарыг өгөөч.

Тэгээд бид нар энэ хуулийг харсаар байтал өсвөр насныхан маань жирэмслээд дууслаа. 13-тай, 14-тэй хүүхдүүд ... /минут дуусав/

**П.Анужин:** Булгаа сайд хариулна. 2 сайд хоёулаа хариулах юм байна. Бас энэ Жаргалмаа гишүүний сая асуултад хэлэхэд өсвөр насныхан жирэмслээд дуусах нь хаашаа юм. Гэхдээ энэ маш ноцтой асуудал байгаа. Тэгээд өнгөрсөн хоёр 7 хоногийн өмнө Нийгмийн бодлогын байнгын хороо дээр бид нар уг асуудлыг бас сонсохоор төлөвлөж байсан боловч тодорхой шалтгааны улмаас асуудал хойшлогдсон байгаа. Удахгүй энэ бол бас Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэгдэх асуудал.

Жаргалмаа гишүүний асуултад гүйцээж Булгантуяа сайд, Чинзориг сайд хариулъя.

**Х.Булгантуяа:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Геронтологийн төв дээр бас нэмж хэлэхэд сая ахмадын чуулган хийхэд 10 сарын 01-нд бас энэ Геронтологийн төвийн асуудлыг бол маш их ярьж байсан. Ерөөсөө ганц хүсэн хүлээж байгаа тэгээд үүнтэй холбоотойгоор ахмад настны томоохон хөтөлбөрүүдийг бас зохион байгуулах энэ асуудлыг бол бас ярьсан.

Батсүмбэр сумаас ахмад настны үндэсний төв хүртэлх хатуу хучилттай авто зам, гүүр 10,7 км. Энэ бол 2024 оны төсөвт 13,3 тэрбум төгрөгийн төсөвтэйгөөр суугдсан. Үүн дээр манай Төв аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд бол маш их дэмжиж бас хамтарч ажилласан. Батсүмбэрт манай ахмадын төвд маш олон ахмадууд байдаг. Хэрвээ шаардлагатай яаралтай тусламж дуудаад машин тэргээр очиход бол энэ зам энэ тэр нь маш хэцүү юм байна лээ. Тэгэхээр бараг хэр баргийн машин бол очихооргүй, их цастай, бороотой үед энэ тэр бол очихооргүй

байсан. Энэ бол 2024 оны төсөв дээр бас суугаад явж байгаа.

**П.Анужин:** Чинзориг сайд асуултад гүйцээж хариулъя.

**С.Чинзориг:** Тэгэхээр Геронтологийн төв тэр 36 ортой эмнэлгийнхээ барилгад ингээд 11 сард сарын сүүлээр шилжээд орчихно оо, Жаргалмаа гишүүн ээ. Одоо 24 оны төсөв дээр нэг 315 сая төгрөг тусаж байгаа юм. Түүгээр нөгөө гадна инженерийн шугам сүлжээ хийгдэх юм. Тэрийг нь тэр байгууллага нь энэ онд нь багтаагаад хийлгэчихье. Тэгээд он гарахаар тэр 315 сая төгрөг, он гарангуут нь бид авчихъя гэдэг ийм зүйл яриад явж байгаа юм. Тэгэхээр энэ ондоо 11 сардаа багтаад орчихно.

Ер нь тэр өсвөр насныхны ялангуяа нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой асуудал дээр ер нь хаана хаанаа бас жаахан анхаарал хандуулах ёстой асуудал байгаа юм байна лээ. Зөвхөн тэр кабинеттай болсноор үүнийг шийдчихгүй болов уу гэж бодож байгаа. Ер нь тэр иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээндээ өсвөр насныханд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгодог байх чиглэлийн асуудлыг Боловсролын яамтай, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай энэ тэр хамтарч маш их ажил хиймээр байгаа юм байна лээ. Ний нуугүй хэлэхэд бол өсвөр насны охидын жирэмслэлт ... /минут дуусав/

**П.Анужин:** Энэ асуудал бол маш бас чухал анхаарч ажиллах ёстой асуудал мөн. Жаргалмаа гишүүн хариулт хангалтгүй байна гэж үзэж байгаа учраас Жаргалмаа гишүүнд нэмэлт 1 минут өгье. Асуултаа тодорхой асуугаад байгаа. Жаргалмаа гишүүн тодруулъя.

**Б.Жаргалмаа:** Би нөгөө л Батсүмбэрээ л ахиж асуугаад байгаа юм, тийм ээ. Ер нь бид нар нөгөө эмнэлгийнх нь үйл ажиллагааг бас

магадалж өгье. Тэнд зөвхөн ахмадууд нэг юу ч хүлээж суугаагаа мэдэхгүй суух биш, тэнд хөгжил явдаг байя. Ядаж л бид нар машин тэргээр гадаа салхинд гаргадаг болох тэр боломжийг нь нээх үүднээс машин техниктэй болгоё, гал зуухыг нь биш ээ уурын зуухыг нь ажиллуулдаг больё. Тэгээд ийм зүйлүүд ярьж байсан. Тэгээд энэ ажлууд ер нь бодит үр дүнгээ өгсөн үү? Хэдэн хөгшчүүлээ аваачаад тэнд орхичихдог, нэг хэдэн эмч нар нэг авч байгаа хэдэн төгрөгтөө бас ажиллахад маш хүнд байдаг. Бид нар бүгдээрээ тэрийг мэдэж байгаа. Тэгэхээр энэ дээр ер нь хөрөнгө оруулалт, санхүүжилт ер нь хэр байгаа юм бэ? Ер нь ахмадын асрамж халамжийн төвөө бид нар хот руугаа авчрах, эргээд хүүхдүүдтэй холбох, тэд нарын насжилтыг нь нэмэгдүүлэх, эрүүл чанартай насжилтыг бий болгохын төлөө яг энэ ахмад настны бодлого дээрээ бид нар юу хийх ёстой юм бэ? Энэ зөвхөн хөрөнгө оруулалтын асуудал биш яг бид нар бодитой гэх юм бол хөрөнгө оруулалтаар юу хийж чадсан юм бэ гэдэг зүйл дээр л дэлгэрэнгүй хариулаад өгөөч.

**П.Анужин:** Энэ 11 цагаас бас энэ танхимд чухал хуралдаан төлөвлөсөн байгаа. Манай Байнгын хорооны хуралдаан бас нэлээн урт явж байна. Тэгэхээр яг энэ асуудлыг Жаргалмаа гишүүн саяын асуултыг Булгантуяа сайд та тодорхой бас бичгээр хариултаа өгөөд та 2 нэг уулзаадхаарай. Тийм ээ.

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууснаар өнөөдрийн асуулт асуух гишүүдийн ингээд нэрс дуусаж байгаа юм. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Өнөөдөр энэ хөдөлмөр эрхлэлтийн асуудал бол маш чухал байгаа. Өнөөдөр Монгол Улсад нэг 44600 эмэгтэй ажилгүй байна. Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бол хүн амын бүлэгт чиглэсэн ажлын байр хөдөлмөр эрхлэлтийг бий болгоно гэдэг ийм заалт

орсон байгаа юм. Тэгээд энэ эмэгтэйчүүд рүү чиглэсэн ажлын байрны асуудлыг 24 оны төсөвт хэрхэн яаж тусгаж байгаа вэ, 1.

2-т, бид нар чинь нөгөө Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх гээд хуулийн төсөл өргөн бариад хэлэлцэх эсэх асуудал нь шийдэгдчихсэн байгаа. Тэгээд би бол Хан-Уул дүүрэгт бас нэг бизнес эрхлэгчид эмэгтэйчүүдийн төв гээд ийм саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд өгсөн. Харамсалтай нь бол сая энэ хөрөнгө оруулалтыг харахад тусгаагүй байна. Энэ дээр та бүхэн маань хөөцөлдөж ажиллах юм уу, үгүй юм уу? Энэ хандлагаас харахад бол Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дэмжихгүй байна гэж би үзэж байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг анхаарахгүй байна. 24 онд хэрхэн яаж энэ хүн амын бүлэг рүү чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар тайлан тавихыг чинь би их гайхаж байна. Үүнд 1 дүгээрт хариулт байлаа.

2 дугаарт, бас өгөх сайхан мэдээ гэвэл УИХ дахь 13 эмэгтэй гишүүн энэ хөдөө орон нутагт байгаа сум, энэ сургуулийн дотуур байрны нолийн асуудлыг бол бүрэн шийдвэрлэх зорилтыг ийм 4 жилд тавьсан. Тэгээд сая 24 оны төсвөөр энэ нийт төсвийг 100 байсныг 160 тэрбум болгоод ингээд шийдэж байгаа. Энэ нь бол нөгөө бидний хүүхэд хамгааллын чиглэлд хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах асуудалд бол анхаарал хандуулж тодорхой шийдэл гаргаж байгаагийн нэг илэрхийллээ гэж ингэж бодож байна.

3 дугаарт, миний хэлэх гэж байгаа зүйл бол ЭМЯ-тай холбоотой. Тойргийнхоо асуудлыг гишүүдээс илүү мэддэг хүн бага л даа. Салбарын яам нь мэддэггүй байхад гишүүд нь л мэдэж байдаг. Энэ утгаараа эрүүл мэндийн салбартай холбоотой асуудлаар бол хэд хэдэн санал өгсөн. ЭМЯ бол асуудалд

үнэхээр хариуцлагатай хандсан. Би талархаж байна. Ялангуяа анхан шатын эмнэлгийн тусламж үйлчилгээ хамгийн гол асуудал. Энэ чиглэл дээр бол тоног төхөөрөмж болон ӨЭМТ байгуулах асуудалд Чинзориг сайд болон Эрүүл мэндийн яамны хамт олон хариуцлагатай хандсанд талархаж байна. Одоо Эрүүл мэндийн сайдаас алив Чинзориг танаас асуух гээд байна, би. Энэ өнгөрсөн онуудад эрүүл мэндийн салбарт энэ тоног төхөөрөмжтэй холбоотой, автомашины парк шинэчлэл, засвартай холбоотой санхүүжилт тун хангалтгүй байсан. Сонгогдсон гишүүдийнхээ хувьд бид нар тойргийнхоо эрүүл мэндийн байгууллагаас хүссэн тэр тоног төхөөрөмжийг өнгөрсөн хугацаанд үнэндээ өгч чадаагүй. 24 онд эрүүл мэндийн байгууллагуудыг анхан шатын гэж ад үзэхгүйгээр шаардлагатай тоног төхөөрөмжийг нь өгөх ийм хангалттай хэмжээний хөрөнгө оруулалтыг суулгаж чадсан уу. Чадаагүй бол Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд болон УИХ дахь 13 эмэгтэй гишүүн бид санаачилга гаргаад энэ чиглэлийн зарчмын зөрөөтэй санал гаргаж төсөвт суулгах ийм бодолтой байна. Тийм учраас бол үүн дээр нэг байр сууриа илэрхийлээд өгөөч.

Үүний дараа бол би тодруулах асуултаа тавья гэж ингэж бодож байна. Уучлаарай Анужин дарга аа. Хавдрын эмнэлэгтэй холбоотой асуудлыг хэн тавиад байгаа юм. Раднаасэд гишүүн тавиад байгаа юм. Тэгээд яах вэ, сошиалаар бас л баахан шүүмжлэл өрнүүлсэн л байна лээ. Сумд соёлын төв хэрэггүй гэж хэн чамд хэлсэн юм гээд л. Тэгэхдээ ер нь асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэх нь зүйтэй л дээ. Өнөөдөр сумын иргэдэд хавдраас болж хүнд байдалд орж байгаа, амь насаа алдаж байгаа иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ чухал уу, соёлын төв чухал уу гээд ач холбогдлоор нь бодоод үзэх юм бол мэдээж хэрэг гэр бүл болгонд өнөөдөр хавдартай хүн байна ... /минут дуусав/

**П.Анужин:** Булгантуяа сайд асуултад хариулъя.

**Х.Булгантуяа:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Манай яамнаас Сангийн яам руу очоод хасагдсан зарим төсөл, арга хэмжээнүүд байгаа. Түүний нэг нь Сангийн яамнаас энэ Хан-Уул дүүргийн Сарангэрэл гишүүний 3,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй энэ төсөл, арга хэмжээг газаргүй, ГЭЗҮ-гүй гэдэг үндэслэлээр нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Сангийн яам руу явуулсан ч гэсэндээ хасагдсан байсан. Улсын Их Хурлын чуулган дээр бас Сангийн яамныхан бас үүн дээр тайлбар өгч байсан.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бол бид нар гарч байгаа зээллэг хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зээллэгүүдийн доор хаяж 50 хувийг бол эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт рүү чиглүүлж эмэгтэй бизнес эрхлэгчид рүү чиглүүлж гаргана. Үүнтэй холбоотойгоор уг нь энэ хуулийн төсөл батлагдвал бид нарт бас хэрэгтэй байгаад байгаа юм. Яг эмэгтэй бизнес эрхлэгчид гэхээр юу гэсэн үг юм? Захирал нь эмэгтэй болохоор юм уу, ажилчдынх нь ихэнх нь эмэгтэй болохоор юм уу, эс үгүй бол хувьцаа эзэмшигч нь эмэгтэй болохоор юм уу гэдэг энэ хуулийн томъёоллыг гаргаж өгөх юм бол бид нарт уг нь маш их нэн чухал хэрэгтэй байгаад байгаа юм.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор бас бидний хийсэн судалгаагаар эмэгтэйчүүдийн хувьд хамгийн чухал асуудлууд нь зээл тусламжаас гадна ялангуяа хүүхдийн сургууль, цэцэрлэгийн хамрагдалт, хүүхдээ наашаа цаашаа бид нар зөөгөөд, хүүхдийнхээ аюулгүй байдал, эрүүл ахуйд ингээд анхаараад, хөдөлмөр эрхлэхэд хүнд байна гэдэг асуудлыг ярьсан. Тийм учраас 2022 он оны 09 сарын 01-нээс Боловсролын яам, нийслэл ингээд хамтраад нийслэл Улаанбаатар хотын цэцэрлэгийн хүүхэд хамрагдалтыг бол

нэмэгдүүлсэн. Үүн дээр бол нэлээдгүй ахиц дэвшил гарсан. Бид энэ онд уг нь энэ хууль нь батлагдвал гээд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт дээр бас хамтдаа хэрэгжүүлнэ ээ гээд манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ажлын хэсэг гараад нөгөө ОУБ-тай Европын сэргээн босголтын банкттай бас ингээд ажиллаж байсан болов чиг хууль батлагдаж өгөхгүй байгаатай холбоотойгоор зарим төлөвлөж байсан ажлууд маань бас хийгдэж чадахгүй байгаа асуудал байгаа.

**П.Анужин:** Чинзориг сайд гүйцээж хариулъя. Тодорхой хариулчих аа, тэр тоног төхөөрөмж машины асуудлыг яах вэ гээд.

**С.Чинзориг:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Өөрөө салбарын сайд байсан хүн, зовлон мэддэг хүн сайхан гэж үг байдаг. Зовлон мэддэг хүн тэгээд бас салбарынхаа юманд анхаарч байгаад их баярлаж байна. 23 оны төсөв дээр салбарын тоног төхөөрөмж гэж мөнгө төсөвлөөгүй байсан. 24 оны улсын төсөв дээр эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн зардалд 43 тэрбум төгрөг төсөвлөсөн. Гэхдээ үүнээс 12 тэрбум төгрөг нь яг салбарын тоног төхөөрөмж гэсэн ийм ангиллаар төсөвт туссан гэдгийг хэлье.

**П.Анужин:** Тэр Бизнес эрхлэх эмэгтэйчүүдийг дэмжих тухай хуулийн төслийг Сарангэрэл гишүүн маань санаачлаад бүх эмэгтэйчүүд нийлээд өргөн барьсан байгаа. Чинбүрэн гишүүн ажлын хэсгийг ахалж байгаа, тийм ээ. Тэгэхээр энэ асуудал дээр бас эрчимтэй ажиллаж Байнгын хороо анхаарч ажиллаж байгаа. Энэ асуудал дээр бас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам анхаарал тавьж тийм ээ, бас хамтран ажиллахыг хэлмээр байна.

Асуулт асуух гишүүд дууссан. Тийм үү. Төсвийн төсөлтэй холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүд дууслаа.

*Зарчмын зөрөөтэй санал бол  
Байнгын хороонд ирээгүй байгаа.*

*Монгол Улсын төсвийн төслийн 2  
дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх  
Байнгын хорооноос гарах санал,  
дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн  
Жигжидсүрэнгийн Чинбүрэн Төсвийн  
байнгын хорооны хуралдаанд  
танилцуулна.*

*Монгол Улсын 2024 оны төсвийн  
төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Байнгын  
хороогоор хийж дууслаа.*

*Нийгмийн бодлогын байнгын  
хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал  
үүгээр өндөрлөсөн тул Байнгын хорооны  
хуралдаанд оролцсон гишүүд болон  
ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*П.ОЮУНГЭРЭЛ*